MO016内 2011/3/23 00:52 AM 頁面1

БУРХАНЫ НОМ



ДАРМАПАДА

MO016內 2011/3/23 00:52 AM 頁面2

DDC
294,3
Ц-956

Дармапада

Хоёр дахь хэвлэлт

Зохиогчийн эрх “Гэгээрэлд хүрэх зам” сан
Улаанбаатар © 2008 он

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан болно. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх болон бусад хэлбэрээр олшруулахыг хориглоно.

НЭПКО паблишинг компанид
эхийг бэлтгэв.

Цаасны хэмжээ 175×250
Хэвлэлийн дизайныг Ч. Мөнхбаяр
Чимэг зургийг М. Чимэддорж

ISBN 978-99929-67-11-0

Printed and donated for free distribution by
The Corporate Body of the Buddha Educational Foundation
11F., 55 Hang Chow South Road Sec 1, Taipei, Taiwan, R.O.C.
Tel:886-2-23951198, Fax:886-2-23913415
Email:overseas@budaedu.org
Website: http://www.budaedu.org
This book is for free distribution, it is not for sale.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

MO016内 2011/3/23 00:52 AM 頁面3

Гарчиг

I.	ХОСЫН ЦОМОРЛОГ	4
II.	СЭРЭМЖИЙН ЦОМОРЛОГ	10
III.	СЭТГЭЛИЙН ЦОМОРЛОГ	14
IV.	ЦЭЦГИЙН ЦОМОРЛОГ	16
V.	ТЭНЭГИЙН ЦОМОРЛОГ	20
VI.	МЭРГЭДИЙН ЦОМОРЛОГ	24
VII.	АРШИЙН ЦОМОРЛОГ	28
VIII.	МЯНГАТЫН ЦОМОРЛОГ	30
IX.	НҮГЭЛ ХИЛЭНЦИЙН ЦОМОРЛОГ	34
X.	ШИЙТГЭЛИЙН ЦОМОРЛОГ	38
XI.	ӨТЛӨХИЙН ЦОМОРЛОГ	42
XII.	ӨӨРИЙН ЦОМОРЛОГ	46
XIII.	ЕРТӨНЦИЙН ЦОМОРЛОГ	48
XIV.	ГЭГЭЭРЭХИЙН ЦОМОРЛОГ	52
XV.	АМГАЛАН, ЦЭНГЭЛИЙН ЦОМОРЛОГ	58
XVI.	ЖАРГАЛАНГИЙН ЦОМОРЛОГ	60
XVII.	УУР ХИЛЭНГИЙН ЦОМОРЛОГ	64
XVIII.	АРИУН БУСЫН ЦОМОРЛОГ	68
XIX.	ҮНЭНЧ ШУДАРГЫН ЦОМОРЛОГ	74
XX.	ЗАМ МӨРИЙН ЦОМОРЛОГ	78
XXI.	ХЭСЭГ БУСГИЙН ЦОМОРЛОГ	84
XXII.	ГАСЛАНГИЙН ЦОМОРЛОГ	86
XXIII.	ЗААНЫ ЦОМОРЛОГ	88
XXIV.	ШУНАЛЫН ЦОМОРЛОГ	92
XXV.	ХУВРАГИЙН ЦОМОРЛОГ	96
XXVI.	БЯРМАНЫ ЦОМОРЛОГ	100

MO016內 2011/3/23 00:53 AM 頁面4

I бүлэг

ХОСЫН ЦОМОРЛОГ

1:1
Үзэгдэл юмс сэтгэлээс үүдэлтэй
Үргэлж сэтгэл түрүүлж залаастай
Гасалгах муу сэтгэлийн араас
Гай зовлон байнга дагаастай
Шаранд чирэгдэх тэрэг тоног шиг
Шаналал зовлон чамаас зүүгдээстэй.



1.2
Үзэгдэл юмс сэтгэлээс үүдэлтэй
Үүдэх эхлэл нь сэтгэлээс гаралтай
Үнэнхүү зөв сайн сэтгэлтний
Үзэх эдлэх нь баясгалан жаргалан
Үлэмжийн баясгалан ингэж бүрэлдээд
Үргэлж хажууд нь сүүдэр шиг дагана.

1:3
Энэ ч намайг дээрэмдэх мэтээр
Эндээс ч намайг муучлах мэтээр
Эсвэл тэднүүс хараах мэтээр
Энэчлэн хонзогноводос хилэнцээс салахгүй ээ.

MO016內 2011/3/23 00:53 AM 頁面5

1:4
Тэр ч намайг дээрэмдэнэ гэхгүй
Тэндээс ч намайг гоочилно гэхгүй
Тэгвэл эднүүс муучилна гэхгүй
Тэгж уучилбал хилэнцээс сална.

1:5
Занах уурлах чиний хилэн
Замын дайсныг цогцлоож босгоно
Заналгүй уучилж, өшилгүй мартвал
Зам цэвэршиж дайсан арилна.

Хорслыг хорслоор ялдаггүй нь
Хорвоо ертөнцийн үнэн
Өшийг өршөөлөөр дардаг нь
Өнө мөнхийн зам.



1:6
Элээх биеийг олж төрөгсөд
Ээлжээ дуусгаад буцах гийчид
Эргүүлж дуудах ухлээ санагч л
Элдэв хэрүүлтэй хөөцөөлдөж
зовохгүй ээ.

MO016內 2011/3/23 00:53 AM 頁面6



1:7
Алиа зугаа, цэнгэлийн хойноос
Алийгаа алдан шунан хөөвөөс
Алдуул морь шиг шунал нь алдуурч
Амин насны уяа сулраад

Асар эрчит хуй салхинд
Агшнаа хугарах хувхай мөчир шиг
Ад хорлолын найрын идэш,
Аюулт шулмын зууш болном.

1:8
Амьдрах биехэн хэврэгийг санаж
Ассан тачаалаа атган татаж
Атгаг хүслээ хазаарлан чангааж
Авралд итгэж, шамдан гэгээрвэл

Хар салхи алгадаад халирах
Хадан уул шигээр буян батжиж
Хатуу, гашуунаар хорлогч шулам
Хаанаас нь ч элтэлж барахгүй болно.

1:9
Өргөл барьц руу өнгийж
сарвайж
Өнгөнд шунахгүйн номоосоо
сатаарч
Өдрийг барагч лам
төдийтэн
Өгөөмөр гэгээрлийн үнийг
барна.

1:10
Сэтгэлийн гэмүүдээ хөнөөлгүй
болгож
Сэрэмж хатуужлаар сахилаа
дагагч л
Үзэх талаасаа ч хувраг мөн өө
Үлэмж гэгээрлийг дагагч
мөн өө.

1:11
Утгатай сэхээрэлтэйг
ухаарахгүй атлаа
Утгагүй мунхагийг эндүүрэн
дагагч
Угтаа хэзээ ч үнэнийг
танихгүй ээ
Учрыг тунгаах хувь
хүрэхгүй ээ.

MO016內 2011/3/23 00:53 AM 頁面7



1:12
Үнэн номыг үнэнээр нь тайлбал
Үзтэл хуурмагийг ялган танивал
Ухаарч таних чадвар мөн
Улмаан гэгээрэх замнал мөн.



1:13
Дээвэр туурга муутай гэрийн
Дээрээс дусаал гоожих мэтээр
Тэвчээр бясалгалын цоожгүй сэтгэлд
Тэчъяал, шунал цутгаж нэвчинэ.





1:14
Сайн дээвэр, овоо туурга
Саатуулж дусаалыг хорихын адилаар
Сайтар бясалгал, үнэн ухаарлаар
Садарлах, шунах гэмүүдийг хаана.

1:15
Элдэв нүглийг үйлдэгч бүхэн
Энэ ч тэр ч төрөлдөө зовно
Энэ төрөлдөө эдэлсэн зовлон
Ирэх төрөлд ч зовоохоор хүлээнэ

Эндэл осол гэмээ танихад
Элэг эмтрэн бүр ч гасална.

1:16
Элдэв буяныг бүтээгч бүхэн
Энэ ч тэр ч төрөлдөө жаргана.
Энэ насны баясгалан жаргалан
Ирэх төрөлд ч жаргаахаар
хүлээнэ

Саян буяныхаа ур шалтгийг
Санах амсахад сэтгэл баясна.

MO016內 2011/3/23 00:53 AM 頁面8



1:18
Энэ насны баясгалан жаргалан
Эцэс хойтдоо ч үргэлжилж болно
Эрхэм буяныг үйлдэгч болгоны
Эргэх төрлүүд үүрдийн баясгалан

Төгс сайн буяны үрээр
Төрөл дээшлэн гэгээрэлд хүрнэ
Түгээмэл баясгалан, амгалан жаргалан
Төгөлдөр сайхнаар цогцлон оршино.



1:19
Санваар сахилаа барихгүй хуврагууд
Сарвайх шуналаа татахгүй сүсэгтнүүд
Хүний хөрөнгийг “минийх” гэж
Хүүдэгнэж хоосон сайрхагч адил аа.

Амандаа маани буувтнаад буувтнаад
Алд дэлмээр сунаж мөргөөд ч
Ач гэгээрлийг хүртэж чадахгүй
Аврал энэрэлд багтаж орохгүй.



1:20
Зөв амьдарч, зөв үйлдвэл
Зөрүү буруу шуналаа дарвал
Сурсан, дуулсан багадах нь үгүй
Судалсан, залбирсан дутах нь үгүй.

Сэтгэлийн гэмүүдээ шүүрдэн хаяад
Сэнхрүүлэгч гэгээрлээр арилутган сүлэгч
Энэ насандаа гэгээрлээр замнагч
Ирэх төрөлдөө ч ялагдашгүй дээшлэгч.

MO016內 2011/3/23 00:53 AM 頁面10

II бүлэг

СЭРЭМЖИЙН ЦОМОРЛОГ

2:21
Сэрэмж хичээл нь амьдын зөв зам

Сэрж хянахгүй бол алддаг нь жам

Сэрэмж төгөлдөр бол баарах нь үгүй

Сэрэмжээ гээгсэд баярлах нь үгүй.

2:22
Ухаан сэхээтнүүд сэрэмжийг чухалчилж
Урагшлах замынхаа хань болгоно
Сэрэмж гэдэг итгэлтэй хань
Сэтгэл баясгаж, үйлс зөвтгөнө.

2:24
Сэрэмж төгөлдөр ухаалаг хүн
Сэрэмжилж цээрлэж, явдлаа хянаж
Сэтгэл санаагаа номоор залж
Сэрсэн, гэгээрсэн алдарт хүрнэ.



2:23
Сэхээтэй ухаантай хүмүүс үргэлж
Сэтгэлдээ тунгааж, үйлсээ хянана
Сэрэмжээ хичээж, буянд шамдаж
Сэтгэшгүй нирвааND дөхсөөр хүрнэ.

MO016內 2011/3/23 00:53 AM 頁面11



2:26
Мунхаг тэнэгүүд дэвжих нь бүү хэл
Муугийн намгаас сугарч дийлэхгүй
Эгэлгүй ухаантнууд л сэрэмж хичээлээ
Эрдэнэс чандманийн далайд хувиргана.

2:25
Үнэн ухаантан сэрэмж хичээлээр
Үлэмжийн тэвчээр сайн зүтгэлээр
Үер усанд автахгүй, живэхгүй
Үзэсгэлэнт арал мэт оршиж цогцлоно.

2:27
Амтших хүсэл, хорхойсох дурандаа
Амаа мэдүүлж битгий жолоодуул
Алхах тоолондоо сэрэмжилж хичээвэл
Аз жаргалаа тогтооож эдэлнэ.

2:28
Авхаалжит мэргэд гэнэн мунхагаа
Асар гэрэлт сэрэмжээр солиод
Аугаа гэгээрлийн замаар өгсөж
Аюул зовлонгоо бэлд нь орхино.

Зовлонгийн далайд хөвж яваа
Зон олны гасланг болгооож
Хосгүй ухаарлын оргил дээрээс
Хорвоог өнгийж тольдох болно.

2:29
Хонины морийг тоосондоо булаад
Холдон тасрах ажнай хүлэг шиг
Ухаарч сэрсэн хичээл билэгтэн
Унтаа мунхагуудаас цойлон дээшилнэ.



2:30
Үнэхээр саяны яриад байгаа
Үлэмж чухаг сэрэмжийг хичээснээр
Эзэн хурмастын дээд төрөлд
Эрхэм Индра хүрсэн байх юм.

Эрхгүй туулснаа бодон бодон
Энэ хичээлээ санагч Тэнгэрс
Алмай мунхагийг яавч мууашаана
Аврах сэрэмжийг ямагт сайшаана.

MO016內 2011/3/23 00:53 AM 頁面13



2:31
Сэрэмжтэй хувраг түүндээ баяртай
Сэрэмж алдахыг аюулд бодоостой
Сэтгэлдээ асаасан ухаарлын гал нь
Сэвтээх шуналыг түймэрдэх бөлгөө.

2:32
Сэрэмжтэй хувраг болгоомжгүй явдлаас
Сэжиглэж цээрлэн аюулд тоолно
Сэвтээх аюулаас цэрвэгч хувраг
Сэтгэл гэгээрэн нирваанд ойртоно.

MO016內 2011/3/23 00:53 AM 頁面14



3:33
Аяа сэтгэлд амгалан үгүй
Амсхийх төдий чөлөө байхгүй
Альбин зольбин мэх нь дуусахгүй
Амгаа хазаараар залагдах нь үгүй

Эрхий мэргэн нумаа онилж
Эрчим сумаа шагайх мэтээр
Элдэв ончроо дүүрсэн сэтгэлээ
Эгцэлж, цэгцэлж явах нь чухаг

3:34
Илбээс хахууль хууртан үмхээд
Эрэгт дэмий цовхчих загас шиг
Эндүү, дэндүү үймрэх сэтгэл
Эрлэг шулмын идэш мөн өө.



3:35
Өөрийнх атлаа баригдах нь үгүй
Өөр дээр тогтох нь үгүй
Огторгуйд бултан одогч
сэтгэлийг
Оёоргүй алс руу булзагч сэтгэлийг

Уургалж барих нь мөрөөдөл мөн
Улмаан жаргалан мөнийн мөн
Атганд орж баригдсан сэтгэл
Аз жаргалаар булах болно.

3:36
Сэтгэл санаа жолоо байхгүй
Сэлиэ ч, ниснэ ч, харвана ч
Сэрэмжилж хянаж, ажин байж
Сэтгэлээ манавал жаргалаа ч манана.



3:37
Тэр гээд тоймлох дүрсгүй
Тэнд гээд тогтоох аргагүй
Тоймгүй, барьцгүй хүний сэтгэлд
Тогтох, нуугдах аюул тоогүй.

Хэсүүл сэтгэлээ хоргоон ногтолж
Хэрсүү ухаарлын хоргонд номхроогч
Ад шулмын аюул хөнөөлөөс
Аварч өөрийгөө хамгаалах болно.

3:38
Номын гэрэл тусаагүй сэтгэл
Номхроно гэвэл тусаар бага аа
Номхон амгаланг олоогүй сэтгэлд
Номын гэрэл тусаар бага аа.



3:39
Сэтгэлийн жолоогоо алдаж тавиагүй
Сэхэшгүй мунхагийн хүлээсэнд ороогүй
Сайн буяны гэгээрлийг дагагчид л
Санаа бодолдоо айдасгүй оршино.

3:40
Олдсон биеийн хэврэгийг бодогсод
Оюун сэтгэлээ л цайз болгоно
Хэрэм цонжийг нь сэрэмжээр өрнө
Хэзээ ч шулам оруулахгүй
өвдөглөнө.



3:41
Агшин зуурт л бие үхнэ
Амин сүнс нь сугарч гарна
Унанги дархи шиг хүүр яс
Унаж хоцроод хаягдах болно.



3:42
Нэг дайсан нөгөө дайснаа
Ниргэж хөнөөх нь аюух мэт
Эндүү буруу жолоотой сэтгэл
Эргэж хөнөөх нь түүнээс ч нэт.

3:43
Эцэг эхийн хайр халамжаас ч
Энгүй дотно ханийн өргөмжөөс ч
Эрхгүй давдаг энэрэгч байдаг нь
Эгнэгт зөвдсөн сэтгэл л юм шүү.

MO016內 2011/3/23 00:53 AM 頁面16

ЦЭЦГИЙН ЦОМОРЛОГ



4.44
Эвдрэн сүйдэх эрлэгийн орон
Энэ төрлийн дэлхийн орон
Эрхбиш дээхнүүр тэнгэрийн орон
Эдгээрийг гэтлэж яахин одох вэ?

Эрхгүй олон цэцгэн дундаас
Эмтэйг нь таних цэцэрлэгч мэтээр
Орон ертөнцийн уулзварууд дундаас
Одох гэгээрлийн зам нь аль вэ?

4:45
Саруул оюунтай шавь нар харин
Саяны орнуудыг гэтлэхээр замнана
Ачтай цэцгийг таньж түүгч шиг
Авралын номыг дагаж судална.

4:46
Энэ биеэ хөөс гэж танивал
Элдэв амьдралын зэрэглээг мэдвэл
Эрлэгийн илдэнд даагдахаа болино
Илбэт шуламд дийлдэхгүй болно.

4:47
Унтаа нойрмог айлын хотхон
Уруйн үерт хамагдах адилаар
Зугаа цэнгэлийн яргуй хөөгчийг
Зуурдын үхэл авч одно оо.

4:48
Урин тачаангуйн цэцэг хөөгчийн
Ухаан санаа самуурч манараад
Урдах зам дээр үхэл нь тосоод
Унасан навч шиг талийгч болно.

4:49
Балч зөгий цэцгийн ариуныг
Баллаж хөнөөлгүй амтлах адилаар
Хосгүй мэргэд өөрийн замаар
Хорлол хөнөөлгүй гэгээрлээ хөөдөг.

4:50
Өөрийн толгойд буух учиргүй
Өрөөлийн нүглийг битгий дэнсэл ээ
Амьтны нуруу руу бухахын эцэсгүй
Амины нүгэл ба буянаа тунгаа.

4:51
Үзтэл ганган цаасан цэцэг
Үргүй, амтгүй, үнэргүй хувхай
Үгээр чамин хоосон цэцлэл
Үржилгүй цаасан цэцэг адил аа.

4:52
Үзэх өнгө, үнэр төгс
Үзтэл амьд цэцэгс гайхамшиг
Үг хэл, үйл хэрэг нийцвэл
Үнэхээр тэр цэцэг шиг гайхамшиг.



4:53
Асар гоёмсог цэцгүүдийг хэлхэж
Амьд цэцгэн эрхийг сүлжинэ
Ариун үйлүүдээ нийлүүлж залгаад
Авралын буяны аргамж бүтээнэ.

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面18



4:54
Сайхан зандан, цэцэгсийн үнэр
Салхи хаашаа, тийшээ л тарна.
Сайн номын үр л харин
Салхитай, салхигүй зүг зүг тарна.



4:56
Агар зандан, сайхан цэцэгсийн
Анхилах үнэр хэмжээ, зайтай
Арцун сахил, гэгээрлийн мөр л
Асар хурмастад ч хүрэх замтай.



4:57
Буяны үйлийг замаа болгоод
Буруу бодлоо цагдаж хоривол
Буг шулам хорлох зайгүй.

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面19

4:55
Үнэрт зандан, үзэсгэлэнт лянхуа
Үнэхээр анхилам, үзтэл бишрэм
Үлэмж сахилтны ариун мөр
Үүнтэй зүйрлэхгүй ариун тансаг аа.







4:58
Замын гудсын хог балчгаас
Ариун лянхуа ургах нь байдаг аа.

4:59
Замбуу тивийн харанхуй дордсоос
Авран гэгээрэгч төрөн гардаг аа.

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面20

V бүлэг

ТЭНЭГИЙН ЦОМОРЛОГ

5:60
Хульжсан нойртонд шөнө урт аа
Сульдсан тамиртанд аян урт аа
Номгүй мунхагт ертөнцийн харанхуй урт аа.



5:61
Эрдмээр илүү нь олдохгүй бол
Эсвэл тэнцүүтэй ханилахгүй бол
Эргүү тэнэгтэй битгий нийл ээ
Их замыг ганцаараа хөөгтүн.



5:62
Эхнэр хүүхдээ төрөлсөн аминчилж
Эд ба агуурсаа өмчирхөн харамнавч
Өөрийн биеэ ч гээж үхнэ
Өмчирхөж садансаад юуны хэрэг вэ?

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面21

5:69
Адын муу хилэнц заримдаа
Арын үр нь хүлээгдэж боловсорно
Арчаагүй тэнэгүүд иймхэн завсрыг
Амтат бал шиг эндүүрч унадаг аа.

Алзахгүй юм шиг эндүүрч явтал
Айлтгүй юм шиг эрэмшиж явтал
Гамшигт үйлийн үр боловсроод
Гай зовлонгийн аянга ниргэнэ ээ.

5-70
Өвсний үзүүрт тогтох төдийхнээр
Өл залган хатуужин суулаа ч
Нэгэнт л мунхаг төрсөн амьтанд
Нэмэр байхгүй, ухаарч чадахгүй.



5:71 А
Саасан дариудаа шинэхэн сүү
Саармагтаж ээдэхгүй байзнах мэтээр
Саар булай үйлийн үр
Саатаж хүлээгдээд хожмоо боловсорно.



5:72
Өмнөх нүгэл боловсрох цагт
Өмгөөлж хамгаалах арга байхгүй
Өөд шидсэн чулуу адилаар
Өөрөө толгой дээр эргэж унана.

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面23



5:73
Хамбын суудлыг зүүдэндээ мөрөөдөгч
Хамаг хуврагийн тэргүүнд
санаашрагч
Хоймор хавьцаа хундлэл горьдогч
Хоосон толгой тэнэг мөн өө.



5:74
Бурсан хувраг ч, эгэл дордос ч
Буяны гавъяа, алдрын титмийг
Өөрийн нэрэнд наахаар махарч
Өнгөлзөн шунаж хилэнцээ зузаална.



5:75
Алдар хүндийн жим тийшээ
Амар амгалангийн зам ийшээ
Аль нэгийг нь л дагана уу гэхээс
Адилхан хамтад замнах аргагүй ээ.

Ашид гэгээрэгч Бурханы шавь л
Авах шунахаас мөрөө буруулж
Аврагч гэгээрлийн мөнийг таньж
Ариун номын замыг хөөдөг өө.

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面24

VI бүлэг

МЭРГЭДИЙН ЦОМОРЛОГ

6:76
Энэ яагаад бууруу болохыг
Эсвэл тэр нь аврал байхыг
Ялган замчлагч л багш мөн
Ямар ч эргэлзээгүй эрдэнэ мөн.

Чандмань эрдэнийг хайж бэдэрч
Чадал оюунаа барахын хэрэггүй
Ачлалт багшийн зааснаар явбал
Ариун эрдэнийн санд хүрнэ.



6:77
Ухаант хүн мэргэдийг дагана
Угийн тэнэгүүд мэргэдээс дайжна.
Учир таньсан мэргэдийг дагаж
Унахаас зайлж, улмаар гэгээр.



6:78
Асар нүгэлтэн нохор болохгүй
Адаг тэнэгүүд хань болохгүй
Эрдэмт хүнийг алдаж болохгүй
Эрхэм үйлстнээс холдож болохгүй.



6:79
Ухаан санаагаа арилгаж байгаад
Уужуу тайвнаар номлол үзвээс
Урьдын богдсын номын шим
Улмаар чамайг баясгах болно оо.

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面25



6:80
Өмнөдийн тариачин усыг залж
Өөрийн тариа руу шуудуугаар хөтөлнө
Эрхий мэргэн шагайх тусмаа
Эрчит сумаа цэцэн болгоно.

Дүйтэй мужаан хичээж зорсоор
Дүнз модноос урлал бүтээнэ
Ухаант мэргэд явдлаа зассаар
Улам боловсорч гэгээрэлд дөтөлнө.



6:81
Хадан уулыг алгадах салхин
Халтирна уу гэхээс эмтлэх нь үгүй
Хамаг мэргэдийн амгалант сэтгэл
Хараавч, ерөөвч дэнслэх нь үгүй.



6:82
Сарууд ухаантан номлол сонсоход
Самуурах сэтгэлийн шуурга арилна
Савандаа мэлтийх амгалан далай шиг
Санаа сэтгэл номхорч тэнийнэ.



6.83
Ухаарсан хүний амгалан сэтгэлд
Уурлах, баясахын чанар адилхан
Уйлах инээхийн чансаа ижилхэн
Урваж алинд ч хөрвөх учиргүй.

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面26



6:84
Амь бие, авгай хүүхдийн
Аль нэгэнд нь хураах хүслээр
Алт мөнгөнд унаж шунахгүй,
Алба тушаалд үхэн мацахгүй,
Авилга, хулгайн амтанд унахгүй,
Ашдын журмыг хөсөр гишгэхгүй.

Санаа сэтгэл ариун явбал
Сайн буяныг хурааж болно.
Санаж бодох зөв байвал
Шагшаабадыг сахиж дийлнэ.

6:85
Амьдрал мөрний энтээ эргээр
Амьтан хүн дүүрэн бөлгөө.
Аврал гэгээрлийн нөгөө эрэгт нь
Асар цөөхөн нь гардаг билээ.

6:86
Үхлийн жамыг гэтлэх замыг
Үзэх нь бүү хэл олохуйд бэрх
Үлэмж богдсыг дагасан нь харин
Үхлийн голын чанадад хүрнэ.

6:87
Зовлонтой ч гэсэн дассан амьдралаа
Зоригложорхисон гэгээрэх хувьтан
Аглаг буйдыг ганцаараа зорьж
Амгалан жаргаланг мөрөөсөн хөөдөг.



6:88
Ассан шунал, маажсан тачаал
Аль алийг номхотгон дарахад
Авах, эдлэх сэтгэлийн хөөрөл
Аандаа өөрөө номхорч эхэлнэ.

Амгалан гэгээрэлд зорьсон ухаантны
Арга чадал эндээс эхэлнэ.

6:89
Ариун самадийн тунгалаг сэтгэлээр
Аливаа ухаарлаа төгөлдөр болгоод
Ад шуналын хорхой юугаа
Аль төрөхөд нь няцалж орхиод

Аюулт шулмыг гэгээрлийн хүчээр
Айлгаж сүрдүүлж эгнэгт хөөвөөс
Авах, наахын шунал юугаан
Арилгаж биеэсээ эгүүрд хусваас
Золтой гэгээрэлд тэр хүрнэ.
Зовлон бухнээс салж гарна
Энэ насны энэлэнт голыг
Эгнэгт туулж чанадад нь гарна.

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面28

АРШИЙН ЦОМОРЛОГ



7.90
Тачаал, хүслийн аргамжийг
Таслан хаяваас чөлөөт мөн
Аливаа хүлээсийг таслах нь
Аршийн хөөх зам мөн.

7:91
Аль ч нуурыг орхидог
Аянчин шувуу дураараа
Ардаа хоргодох гэр үгүй
Аршийн замнал чигээрээ.



7:92
Олдсоноо түгээх учиртай аршид
Олох хураахын зовлон үгүй
Амгалан хоосон чанарыг таньсан
Ашид чөлөөлөгдөх мөрийг олсон

Орь хүсэл нь гэгээрэл болсон
Онцгой тэдний замнал тодорхой
Огторгуйд ниссэн шувууны мөр шиг
Олж дагахад харин бэрхтэй.

7.93
Арш нар идээнд дурлахгүй
Архи дарсыг огоот хүртэхгүй
Амсах эдлэхийн хүсэл шунал
Ашид тэднийг хэзээ ч зовоохгүй

Аливаа тотгорыг арилган дараад
Амгаланд хүрсэн замнал нь тодорхой
Ариун агаар дахь шувууны мөр шиг
Ажиглаж дагахад мөн л бэрхтэй.

MO016內 2011/3/23 01:38 AM 頁面29



7.94
Эмнэг хүлэг шиг омог, хүслээ
Эдэлгээний морь шиг номхруулж залсан
Эрхэм дээд тийм аршийг
Эрхт тэнгэрүүд ч хүндэтгэн мэхийнэ.



7:95
Хүсэлд үймрэхгүй аршийн сэтгэл
Газар дэлхий шиг ажрашгүй юм
Хүний ертөнцийн адал явдалд
Ганц ч цалгихгүй нуур юм.



7:96
Сэтгэл амгалан бол бие амгалан
Сэтгэл амгалан бол үг хэл амгалан
Үнэхээр ухаарсан төгөлдөр арш л
Үнэн амгаланд хүрэх хувьтай.



7:97
Хурсан бүхэн худлааг бодож
Хуурмагаар үүдсэн нь үнэнийг мэдэж
Алба хэргэмд дурлахгүй болж
Авах, идэхэд сарвайхыг больж

Хүсэх, шунахыг гэтэлсэн арш л
Хүнээсээ дээшилсэн арш агаад
Аугаа сэхээрэгч энэ мөн
Атаархвал зохигч тэр мөн.

7:98
Аршийн заларсан орон болгон
Асга хадат байц ч байсан
Аглаг тал, хөдөө ч байсан
Атар хээрийн нуур ч байсан

Амьтан бужигнасан зээл ч байсан
Ав адилхан цэнгэлийн орон оо.



7.99
Хүсэл тачаалаа гүйцээх нь баяр бус
Хүсэхгүй, тачаахгүй нь өөрөө баяр
Хэний ч шунаагүй тэр л амгаланд
Хэний ч санаагүй баясгалан байдаг.

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面30

VIII бүлэг

МЯНГАТЫН ЦОМОРЛОГ



8.100
Утгагүй үгс олон ч балаг
Утгатай үг ганц ч баялаг.

8.101
Утга учиргүй түмэн мөрүүдээс
Утга тодорхой ганц мөр эрдэм.

8.102
Утга учиргүй түмэн шүлгээс
Уншихад тодорхой бадаг найраг.



8.103
Мянган баатрыг дайн тулаанд
Мянгантаа ялагч баатар бус ба
Өөрийн сэтгэлийн гэмийг ялагч л
Өнөд дуурсах баатар мөн өө.

8.104
Уурлуулагч хүн рүү далайхаас өмнө
Уур луугаа далайж номхотгох чухал аа
Хазаргүй сэтгэлээ хазаарлан дарагч л
Хамгаас гарамгай баатар мөн өө.



8.105
Аугаа гэгээрэгч Бурханы өмнө ч
Атаа хорсолт шулмын өмнө ч
Атгаг хүслээ дарагч баатар л
Автахгүй дийлдэхгүй баатар байдаг аа.



8.106
Сүсэгтэй сүсэггүй
хөнгөмсүү барьцыг
Сүм шүтээндээ зуугаар
өргөснөөс
Ашид гэгээрсэн сайн
номтныг
Агшинхан биширсэн нь
илүү буянтай.

8:107
Бурхан багшийн замаар орсон
Буянт гэгээнийг сүсэглэн дагах нь
Зуун жил тахил өргөж
Зул хүж бадраахаас ачтай.

8.108
Эдийн хонжоо бодсон өргөл
Эрхэм гэгээрлийн тахилтай харшина.
Эргэлтгүй шулуудсан номтонд мөргөвөл
Энэ насны буянтай хоршино.

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面32





8.109
Аавын ээжийн буяныг санагч
Ахас ихсээ ачлан өргөгч
Урт насалж удаан жаргана
Урам зориг дүүрэн амьдарна.

8.110
Зуурдын цэнгэлд, алиа наадмаар
Зугаалж өнгөрөөсөн зуун нас гутамшиг
Зул шиг гэгээрлээр буянд шамдсан
Зуны богинохон шөнө гайхамшиг.

8.113
Үхэх, дуусахыг ердөө саналгүй
Үймэрч барсан зуун жил гутамшиг
Үхэх барахын жамыг таньж
Үнэнийг харсан өдөр л гайхамшиг.

MO016內 2011/3/23 00:54 AM 頁面33



8.111
Үхэх, өтлөхийн эргүүлэг дотор
Үзэж таниагүйн харанхуй мунхагт
Үдэж орхисон зуун жилээс
Үнэнийг таньсан өдөр гайхамшиг.



8.112
Алийгаа мэдэхгүй ардаа хаясан
Авах юмгүй зуун наснаас
Аврал, сэхээрлийн чухлыг мэдсэн
Аугаа ганцхан өдөр гайхамшиг.

8.114
Үхэх төрөхийн эргүүлгээ танихгүй
Үймрэн явагчийн зуун нас
Үнэн гэгээрлийн учрыг таниагчийн
Үдсэн ганц өдрөөс доор оо.

8.115
Эргүүлж унших гэгээрлийн номгүй
Эргэж мөргөх бурхан шүтээнгүй
Буцалтгүй үдсэн зуун оноос
Бурханд сүсэглэсэн өдөр гайхамшиг.

IX бүлэг

НҮГЭЛ ХИЛЭНЦИЙН ЦОМОРЛОГ



9.116
Хилэнц нүглээс сэтгэлээ холдуул
Хичээж зүтгэж буянд ойртуул
Буянаас зайдуу сэтгэл өөрөө
Бузар нүгэлд баясах аюултай.

9.117
Урьдын нүглээ битгий давт аа
Ужиг зовлон, гэнэтийн гаслан
Урьд одоогийн нүглийн үр шүү.



9:118
Сайн буянаа дадал болго оо
Сайн амгалан, үлэмжийн жаргалан
Сайн үйлүүдийн үр юм шүү.

9.119
Муу үйл нь боловсрох хүртлээ
Муу хүн сайхан юм шиг харагдах нь бий
Муу үйл нэг л өдөр боловсорч гүйцэхэд
Муугаа үзэн нүгэл нь нүдээрээ гоожих нь бий.

9.120
Сайн үйл мөн л боловсрох хүртлээ
Сайн хүн жаргахгүй юм шиг харагдах нь бий
Сайн үйл нэг л өдөр боловсорч гүйцээд
Сайхан буян нь нүүр дүүрэн тодроод ирнэ.



9.121
Аливаа нүгэл багадах нь үгүй
Алзахгүй юм шиг битгий бодоорой
Нүхээр дуссаар торх дүүрэх шиг
Нүгэл нүглүүд нийлж арвидна.



9.122
Ариун буян багадах нь үгүй
Арвидахгүй юм шиг битгий чамла.
Рашааны дуслууд арвидан дүүрэх шиг
Ариун буянууд нийлж хурна.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面36

9.123
Оюу эрдэнийн наймаач хүмүүн
Осолтой замыг тойрч аялна
Оюун сайт авхаалжит хүмүүн
Осолдох гэмүүдийг тойрч амьдарна.

9.124
Хүрэх гар шархгүй болбол
Хүнцэл хорыг барихаас айлтгүй
Хүнд мууг хийгээгүй бол
Хүнд хорлол тусахаас айлтгүй.



9. 126
Хүний зарим нь дахин төрнө
Хүнд нүгэлтэй нь тамд унана
Гэгээн буянтан тэнгэрт
заларна
Гэгээрэгчид л нирвааанд хүрнэ.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面37



9:125
Өө гэмгүй хөөрхий амьтсыг
Өст хорлогч хилэнцэт хүний
Өөд шидсэн нүглийн чулуу
Өөрийн толгойд унаж бяцална.

9.127
Үйлдсэн нүглээсээ нуугдах аргагүй
Үүлний цаана, тэнгэрт гарсан ч
Үнэхээр алсын далайд шумбавч
Ур нь боловсорч чамайг гүйцнэ.



9.128
Үхлээс бас зугтаах газаргүй
Үүлтэй тэнгэрээс доохнуур дүүлсэн ч
Үзүүртэй модноос дээхнүүр ниссэн ч
Үхэл чамайг гүйцэхээ л гүйцнэ.

MO016内 2011/3/23 00:55 AM 頁面38

Х бүлэг

ШИЙТГЭЛИЙН ЦОМОРЛОГ



10. 129
Гэсгээл нүглээс бүгд айна
Гэнэт гүйцэх үхлээс ч айна
Өөрийн айдсаар жишээ аваад
Өрөөлийг бүү алж хорло оо.



10.130
Амьтан бүхэн шийтгэлээс айна
Амьд явахыг л цөмөөрөө хүснэ
Амиа хайрладгаа үлгэрлэн санаад
Амь тасалж хөнөөхийг тэвч ээ.



10.131
Аз жаргалын төлөө явахдаа
Аз жаргалаа чам шиг л эрсэн
Амьтан хүнд мууг хийвэл
Аз жаргалыг чи амсахгүй ээ.



10.132
Аз жаргалынхаа төлөө явахдаа
Аз жаргалаа чам шиг л эрсэн
Амьтан хүнд тусыг үйлдвээс
Аз жаргалдаа саадгүй хүрнэ.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面39



10.133
Хатуу үгээр бусдыг дайрвал
Хариу нь адилхан хатуу л ирнэ
Хар толгойд хариу нь буух
Харанхуй хэрүүлийг битгий өд.

10.134
Хамаг сэтгэлээ амгалан болгоод
Хараал ерөөлийг огтоос тоолгүй
Хажуугаас чамайг үгээр дэлдэвч
Хагарсан хонх шиг дуугаа хураа.

10.135
Малчин исгэрч шилбүүр тасхийж
Малын хороо руу үхрээ тууна
Өтлөх, үхэх хоёр нийлээд
Өөрийг чинь үхэл рүү тууна.

10.136
Угийн тэнэгүүд үйлдсэн нүглээ
Ухаарч мэдэхгүй улам зузаална
Урьд одоогийн хилэнц нь нийлээд
Унах тамыг дор нь малтана.

10.137
Гэм хоргүй, зүдэх үйлгүй
Гэнэн хөөрхийг шарлааж зовоовол
Гэсгээл зовлонд өөрөө унаж
Гэмээ эдлэх арван тамтай.

10.138
Элдэв дараатанд сэтгэл зовно
Эрүүл ухаанаа алдаж зовно
Эд хөрөнгөөр үгүйрч зовно
Эрхтэн бие нь өвдөж зовно
Энэлэл гаслал барагдахгүй болно.

10.139
Эрх тушаалтны дараатанд орно
Эрүү ялд хилсээр унана
Элгэн садандаа хаягдаж гасална
Эд баялгаасаа хагацаж хоосорно
Энэ насны баясгалан тасарна.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面40



10.140
Орон гэрийг нь тэнгэр нигээж
Оочих аягагүй цурам дээр үлдэнэ
Ой ухаан нь самуурч мунхарна
Ойчих там л өмнө хүлээнэ.

10.141
Хээр хоноож, хий мацаглаж
Хэвтэр дороо чулуу хийсэн ч
Авах шуналаа татаагүй цагт
Аврал, гэгээрэл хүлээгээд дэмий.



10.142
Амьтныг зовоохоо эгнэгт болиод
Авах шуналаа татаж чадвал
Амьтны нүдэнд гангамсуу харагдлаа ч
Аврaлын замуудыг олж чадна.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面41



10.143
Хүлэг сайн морины зоонд
Ташуур буух шалтгаан байхгүй
Хүлцэнгүй болоод даруу зантанд
Хүнийг уурлуулах шалтгаан үгүй.

10.144
Ажнай хүлэг ташуур өргөхөд л
Амаа булаалдан ухасхийх мэтээр
Ахуй, бие , санаа сэтгэлээ
Агшин бүрд гэгээрэлд зүтгүүл

Аршун номын гэгээн мөрүүд
Алжаалгүй бясалгаж хүрсэн үнэнүүд
Авах зөв дадал сахилууд
Атгагүй үнэнч сүсэг итгэлүүд
Аварч чамайг зовлонгоос гэтэлгэнэ.



10.145
Хаа холуур даялах усыг
Хавчиг сувгаар тариа руу хөтөлнө
Хаашаа ч чиггүй өдөт сумыг
Харваач онилон байгаа ононо

Уран мужаан хэвгүй модыг
Урлаж засаад эдлэл бүтээнэ
Ухаант хүн л сэтгэлээ номхотгож
Улмаар түүнийгээ залах болно.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面42

XI бүлэг

ӨТЛӨХИЙН ЦОМОРЛОГ

11. 146
Үйлийн үрдээ ертөнц шатахыг
Үзэх баясах юу байна аа?
Үнэгэн харанхуйн мунхагт байтлаа
Үзэх гэрлийг хайхгүй, яана аа?



11:147
Амин сүнсийг агуулах аргагүй
Аминд халтай идээгээр дүүрсэн
Араг ясандаа торох төдий
Алд биеэ шинжээд үз дээ.

11:148
Энэ бие эрхгүй өтөлж
Эдгэрэх аргагүй өвчинд баригдаж
Энэлэл зовлонгийн уурхай болж
Эрхгүй үхэх нь гарцаагүй ажгуу.



11:149
Хээр хэвтэх хувхай мөчир шиг
Хэлхээ араг яснуудыг төсөөлөөд
Хэний сэтгэлд баяр төрөх вэ?

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面43



11:150
Энэ бие бол хэлхээ яс ба
Эгэлдэргэж тогтсон махны бүрдэл
Өтөлж, хөгширч, үхэхээс гадуур
Өөр ирээдүй өмнө нь байхгүй.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面44



11:151
Хааны бие, эзэнтний ямба ч
Цагаа ирэхээр үхэж үлтэрнэ
Харин Бурханы номыг дагагч л
Цагийн цагт гэгээрч дээшилнэ.

11:152
Сайн эрдэм багатай хүн
Сарлаг үхэр шиг мунхарч өтөлнө
Хэрсүү ухаан суухын оронд
Хэвэл гүзээ нь сунаж өвхөлнө.

11:153
Амсхийлт үгүй, тасралт үгүй
Автаж эргэлдэх сансарын хүрдэнд
Амь агуулагч –шуналыг эрсээр
Ахин дахин төрөл авсаар...

11:154
Ай гэгээн минь нээсэн нүдээрээ
Амь агуулагч-шуналаа танив аа
Амь агуулах шунал оромжийн
Адар цоорхой, хана хагархайг

Агуулж юуг тогтоох аргагүйг
Амар тайван хоргодох боломжгүйг
Андуугүй таньсан гэгээн сэтгэл
Ахиж ийшээ зүглэх аргагүй.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面45



11:155
Нарны голтойд сүсэг төрөөгүй
Насны галтайд номд бишрээгүй
Өтөлсөн хүн загасгүй нуурт
Өлбөрөх хөгшин шувуу мэтээ.



11:156
Хар нялхаасаа зөвөөр замнаж
Хангалттай буян хураагаагүй аваас
Хэргээ бараад хаягдсан эд шиг
Хэнд ч хэрэггүй гансрах болно.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面46

XII бүлэг

ӨӨРИЙН ЦОМОРЛОГ





12:158
Эхлээд өөрийгөө зөв мөрт
Эгнэгт бат оруулж ав
Өрөөл бусдыг үүнийхээ дараа
Өөд татвал зовлонд унахгүй.

12:157
Энэ биеэ эрхэмлэдэг бол
Эрхбиш үргэлж сэрэмжтэй яв
Хоногт өөрийнхөө зөв бурууг
Хоёроос гурвантаа шинжиж бай.



12:159
Хэн хүнийг сургах гэж
Хэлдэг үгээ өөртөө л хэл
Өөр шиг чинь хэцүү шавь
Өнөө ирээдүйд гарахгүй
Өөрийгөө сургасан хүн шиг
Өндөр дээд багш төрөхгүй.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面47



12.160
Өөр хэнээр захируулан хийх вэ?
Өөрөө өөрийгөө захирч сур
Өөрөө өөрийгөө захирагч хүнээс
Өндөр дээд хаан байхгүй.

12:161
Өөрийн биеийг хорлох хорлол
Өөр хаанаас ч бус, өөрөөс л гарна
Өөрийн хорлолын алмаазан хянгар л
Өөрийг чинь хорложг, огтчиж хяргана.

12:162
Сайхан гоолиг саало модыг
Ороонго идсээр унагааж авна
Саар дайсны хүссэн түйтгэрт
Өөрийн нүглүүд цаламдаж унагаана.

12:163
Нүгэл үйлдэх бусдыг хорлох
Нүгэлтэй амархан, үнэн хялбар
Буян хийх, бусдыг аврах
Бузгай түвэгтэй, нэн ярвигтай.

12:164
Архад гэгээдийг зэвүүцэн үзэж
Арцун номд тэрслэн явагчид
Хулсаа үхүүлдэг түүний жимс шиг
Хожуудаа боловсрох хилэнц тээдэг.

12:165
Өөрийн нүгэл л зовлонд унагаана
Өөрийгөө л хорложг шаналанд унагаана
Өөрөө л хичээж гэмээ засна
Өөрөө л гэтэлж зовлонгоос сална.

Гэм алдаа ч , зөв оноо ч
Хэнтэй ч хуваашгүй өөрөөс эхтэй
Гэмтний гэм, үйлтний нажидыг
Гэтэлгэж хөндлөнгөөс хэн ч засахгүй.



12.166
Өрөвлд тустай байлаа гээд
Өөрийгөө битгий гаргуунд хая
Өөдөлж дэвжих замаа чиглэж
Өнөд түүнээ баттай зорь.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面48

XIII бүлэг

ЕРТӨНЦИЙН ЦОМОРЛОГ



13. 167
Бузар нүглийг ямагт тойроод
Бодлого сэрэмжийг мөнхөд хичээ
Буруу суртлыг дагалгүй явж
Буртагт орчлонгийн эргүүлгээс зайлсхий.



13:168
Өөрийгөө үргэлж сэрээж сэхээрүүл
Өнөд сэрэмжийг ханиа болго оо
Эрхэм гэгээрлийн номоор яв аа
Энэ ба хойд төрөлдөө жаргах болно оо.



13:169
Ариун номд сайн сүсэглэ
Аливаа нүглийг үргэлж цээрлэ ээ
Эрхэм гэгээрлийн номоор яв аа
Энэ ба хойд төрөлдөө жаргах болно оо.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面49



13:170
Орчлон дэлхий хөөс гэдгийг
Онхид хоосон зэрэглээ гэдгийг
Олж таньсан хэн хүнийг
Огтоос эрлэг дийлж чадахгүй.

13:171
Эзэн хааны эрдэнийн сүйх
Энэ ертөнцийн өнгөн тансагт
Эргүү тэнэгүүд автаж унана
Эрхэм мэргэд таниад цэрвэнэ.



13:172
Үүлэн чөлөөгөөр саран гийгээд
Үнэн гээд цацрах мэтээр
Урьдын алдсаа гэгээрлээр засагчид
Улам цаашаа сэрэмжтэй болно.



13:173
Үүл арилан саран гийгээд
Үлэмжийн хорвоог гийгүүлэх мэтээр
Урьдын гэмээ буянаар солиод
Улс амьтныг гийгүүлж болдог.

MO016內 2011/3/23 00:55 AM 頁面50

13:174
Замбуутив харанхуй балархай
Завшаан боломжийг харагч нь цөөхөн
Торны цаана суусан шувуудаас
Тоотой цөөхөн нь мултрах мэт ээ.

13:175
Хүн шувууг нарны тойргоор
Хувь заяа нь хөтлөн эргэнэ
Хувьтай мэргэд ертөнцөөс мултарч
Хорлогч шулмын эрхшээлээс гарна.

13:177
Тэнэгүүд завшааныг олдлоо ч үзэхгүй
Тэнгэрийн оронд төрөл авахгүй
Тэнгэрлэг ухаантнууд л завшааныг алдахгүй
Тэр хэрээрээ төрөл дээшилнэ.



13:176
Ам хэлээ нүглээр дүүргээд
Авсан сахилаа зөрчиж бараад
Ариун номоор тохуу хийгчид
Алдахгүй унахгүй хилэнц гэж үгүй.



13: 178
Орчлонгоос мултарч нирваанд хүрэх нь
Орон дэлхийг эзэгнэхээс ч эрхэм
Оройлж тэнгэрт төрөхөөс эрхэм
Олныг сөгтгөн захирахаас ч эрхэм.

MO016内 2011/3/23 00:55 AM 頁面52

XIV бүлэг

ГЭГЭЭРЭХИЙН ЦОМОРЛОГ



14:179
Ялж гэгээрч дээдэд хүрсэн
Ялгуусан Буддад ялагдал гэж үгүй
Ялж төгсөөд ялалтаас ч хагацсан
Ялгуусан Будда хөтлөгдөнө гэж байхгүй.

14:180
Шунал хүслийн тороос гараад
Шуналыг Будда дарсан билээ
Шуналын тороос гэтэлсэн хүнийг
Шунуулж юугаар хөтлөх билээ.



14:181
Үргэлж бясалган номд шамдсан
Үймрэл үгүй сэтгэл шулуудсан
Үнэхээр гэгээрэлд замнасан хүнд
Үлэмж дээд тэнгэрүүд ч атаархана.

MO016內 2011/3/23 00:56 AM 頁面53

14:182
Ухаант хүний биеийг олох амаргүй
Үгтах үхлийг тосон амьдрах амаргүй
Утга төгөлдөр ном сургаалтай учрах амаргүй
Улмаа дээшилж гэгээрэлд хүрэх амаргүй.



14:183
Бузар нүглийг тэвчиж цээрлэ
Буянтай үйлийг тэтгэж цэцэглэ
Бус басын хүслүүдээ чандал
Бурханы сургаал гэвэл энэ ээ.

14:184
Хүлцэл тэвчээр нь гэгээрэл мөн
Хүслэнгийн дээд нь нирваан мөн
Бардамнал, омгорхол нүгэл мөн
Багш Будда үүнийг сургасан.

MO016內 2011/3/23 00:56 AM 頁面54





14:185
Өрөвл бусдыг шоолж басалгүй
Өмөггүй хөөрхийг жанчиж зовоолгүй
Өөрийн сахилыг зөрчиж гээлгүй
Өлөн ховдогоор идэж уулгүй

Аглаг газар гагцаар амьдарч
Амирлангуй бясалгалаар хичээл хийж
Ашид энэ мэт номоор явахыг
Аврагч Будда сургаж заасан.

14:186
Алтан аадар тэнгэрээс асгаравч
Амирладаг шунал гэж байсан удаагүй
Ахархан насны хүсэхийн зовлон
Анхнаас нь танигч л мэргэн болно.





14:189
Харин тэдгээрт аврал үгүй
Хамгаалж зовлонгоос гэтэлгэх нь үгүй
Гэгээрэх замд хөтлөх нь үгүй
Гэрэл гаргаж аврах нь үгүй.

MO016內 2011/3/23 00:56 AM 頁面55



14:187
Асар тэнгэрийн эдлэн байдаг
Амтат цэнгэл ч жаргалан бишийг
Ашдын гэгээдийн номыг дагагч л
Андуугүй үнэнээр таньсан байдаг аа.

14:188
Айдас хүйдэст автсан хөөрхийс
Аврал эрж чиггүй гүйдэг ээ
Хангайн лусаас, удган модноос
Хавьтсан ойртсоноосоо өмгөөлөл хүсдэг ээ.



14:190
Будда буюу гэгээрэгч бурханд
Бурханы номлосон ном сургаалд
Буянд хөтлөх багш мэргэдэд
Буцалтгүй итгэгч л аврагдах замтай.

Орчлонгийн хүлээс зовлон нь үнэн
Ороолдуулж хүлсэн шалтгаан үнэн
Огоорч зовлонгоос гарах нь үнэн
Оройн дээд авралын зам үнэн.

14:191
Хутагтын дөрвөн үнэнийг танигчид
Хувь заягаа аврах замтай
Хутагтын дөрвөн үнэн хийгээд
Хөтлөх найман мөрийг нь дага аа.

MO016内 2011/3/23 01:53 AM 頁面56



14:192
Хутагтын үнэн ба найман мөр нь
Хувь заяаны аврал мөн
Зовлонгоос гаргах арга мөн
Зол жаргалын зам мөн.



14:194
Гэгээн Будда мэндлэх нь баясгалан
Гэгээрүүлэгч сургаалтай нь учрах баясгалан
Хэрхэвч алдрахгүй сахил нь баясгалан
Хэзээд аврагдан гэгээрэх нь баясгалан.

14:195
Атгаг шуналаа дарсан
Аливаа хүслээ дийлсэн
Ариун гэгээд ба шавь нарыг нь
Ав адилхан дээдлэн мөргө өө.

MO016內 2011/3/23 01:54 AM 頁面57



MO016内 2011/3/23 01:54 AM 頁面58

XV бүлэг

АМГАЛАН, ЦЭНГЭЛИЙН ЦОМОРЛОГ



15:197
Өстөн хартны дундуур
Өршөөж алхвал жаргалан
Өр өшиглөсөн амьтныг
Өровдөж чадвал амгалан.

15:198
Хар хорсол сэтгэлийн өвчний
Халдвар түгсэн голомт дундуур
Харгүй хоргүй яван чадагч л
Хаа ч явсан эрүүл амгалан.

15:199
Ассан хүсэлдээ шатагчийг дагаад
Автаж битгий шуналаа сэрээ
Авах хураах хүслээ сөрөгч л
Амгалан жаргалант мөн болой.

15:200
Аминчлан сувьдаглах юухан ч үгүй
Ашид баясгаланг зоогоо болгогч
Амгалан тэнгэр мэт жаргалант яв аа.

15:201
Яллаа дийллээ гэвч өстөн төрүүлж үлдээнэ
Ялагдан уналаа гэвч өширхөн гомдож зовно
Ялах, ялагдах хоёрыг эгнэгт гэтэлсэн хүн л
Ямагт амгалан жаргах баясгаланд сая хүрнэ.

MO016內 2011/3/23 00:56 AM 頁面59



15:202
Авах хүсэл шиг түймэр байхгүй
Атаа хорсол шиг түйтгэр байхгүй
Алд бие шиг зовлон байхгүй
Амгалан сэтгэл шиг баясгалан байхгүй.

15: 203
Оочих юмгүй өлсгөлөн шаналахын дээд
Орчлонгийн хүлээсэнд төрөх зовлонгийн дээд
Онхид үүнийг танин сэтгэл оюунаа гэгээрүүлж
Огоорч түүнээс салагч л амгалан жаргалант мөн өө.



15:204
Эрүүл саруул бие цогцос эдлэх баялгийн дээд
Эрэхийн зовлонгүй хангалуун сэтгэл амгалан жаргалын дээд
Эерэг сайнаар үлгэрлэгч анд хань нөхрийн дээд
Энэ орчлонгийн хүлээснээс гарах нь хувь заяаны дээд.

15:205
Аглагт тасрахын аяыг дагаад
Амгалан сэтгэлийн амтанд умбаад
Айдас хүйдсээс ангижраан амраагч
Арцун номын шимийг хүрт ээ.



15:206
Дэргэд нь байхад баясгалан болдог
Дээдэс гэгээдтэй учрах нь завшаан
Дороомж мугуйдад унагахаас цаашгүй
Доодос мунхагтай учрахгүй нь завшаан.



15:207
Мунхагтай нөхөрлөх нь насны зовлон
Муу ууршиг нь дайсныхтай жишим
Учир иймээс гэгээн мэргэдтэй
Уулзаж учран нөхөрлөх нь чухал.



15:208
Оюун билэг төгөлдөр гэгээн
Онцгой эрдэмт сайн хүнийг
Олж нөхөрлөж чадаж гэмээнэ
Ододтой орчих саран мэт ээ.

MO016內 2011/3/23 00:56 AM 頁面60

XVI бүлэг

ЖАРГАЛАНГИЙН ЦОМОРЛОГ

16:209
Арцун итгэл, үнэн сүсгээ алдаж будилаад
Авах олохын шуналтай ноцолдон зовлонд унаж
Аммат цэнгэлийн илбээсэнд хуурагдагчид
даруйхан сэрээд
Аврагч гэгээдийн араас орж алдалгүй дагагтун.



16:210
Зугаа цэнгэлийн амтанд орж
Зуурдын таашаал битгий хөө л дөө
Зурвасхан амт нь дуусахын хэрд
Зузаан шаналалд унадаг юм шүү.



16:211
Юунд ч битгий унан дурла
Юу руу ч битгий улайран шуна
Дурласан, шунаснаасаа салахын зовлон
Дурлаагүй, шунаагүй хүнд байдаггүй.



16:212
Ая цэнгэлээс зовлон үүсдэг
Айдас хүйдсийн шаналал үүсдэг
Ая цэнгэлээс чөлөөлөгдсөн хүн
Айдас зовлонгоос бас чөлөөлөгдөнө.

16:213
Дурлан дасахаас зовлон үүснэ
Дуусахгүй айдас шаналал үүснэ
Дурлахгүй дасахгүй чөлөөт тэр хүн
Дуусахгүй айдас, зовлонгоос чөлөөтэй.

16:214
Сэтгэл хоргодох татагдах бүхэн
Сэнж гогцоо болж зовлонгоос уяна
Сэнж гогцоогоо мулталсан хүн
Сэтгэл хоргодох зовлонгоос чөлөөтэй.

16:215
Тачаах янаглах нь шаналал үүсгэнэ
Тачаангүй хүсэл нь айдас үүсгэнэ
Тачаангүй хүслийн айдсаас салагч л
Тачаах янаглахийн зовлон үгүй.



16:216.
Шунах амтшихаас хилэнц үүснэ
Шунах ахихдаа айдас төрнө.
Шунах амтшихаас салсан хүн л
Шунах ахихийн зовлонгоос чөлөөтэй.



16: 217
Явдал суудал бодь бөгөөд түвшин
Ялгаж танин бууу бус зөвийг үйлдэгч
Ялгуусан Бурханы гэгээрсэн замыг дагагч
Ямагт олонд хүндлэгдэн өргөмж, хайрыг хүртэнэ.

MO016內 2011/3/23 01:55 AM 頁面62

16:218
Зорьсон хүсэл нь нирвааны зам нэгэнт болсон
Зовоох шунал, хүслийн гэмээс нэгэнт салсан
Зол учралаар амгалан жаргаланд нэгэнт орогчийг
Зовлонгийн голыг сөрөгч хэмээн олноо хүндлэнэ.



16:220
Энэ ба өмнөх төрөл тутмын
Эрхэм сайн буяны үр шим
Энэ төрлөөс нөгөөд очиход
Элгэн садан шиг тосон авна.

16:219
Алс газар аянд одоод
Алив бартаагаа даван гараад
Амар мэндээр эргэн ирэгчийг
Ах дүүс садан нь баярлан тосно.

MO016內 2011/3/23 00:56 AM 頁面63

MO016内 2011/3/23 00:56 AM 頁面64

XVII бүлэг

УУР ХИЛЭНГИЙН ЦОМОРЛОГ

17:221
Уурлан хорсох сэтгэлээ орхи
Улмаар бардам омгоо орхи
Улайран хөвцөлдөх алдраа орхи
Урхидах зовлонгийн шалтгуудыг орхи оо

Амиа хичээх зовлонгоос салагч л
Аль зовлонгоос хамтад нь салдаг аа.

17:222
Агсам морины амыг татах мэт
Аашхилэнгээ амгайвчлан сойвоос
Унасан унаандаа эзэн мөн өө
Унхиагүй бусад нь морьтой мануухай.



17:225
Амьтанд хорыг хүргэхгүй тул
Алмайтаж сэрэмжээ алдахгүй тул
Аугаа мэргэд зовлонгоос холдож
Айсуй нирваанд дөхөж ойртоно.

MO016內 2011/3/23 00:56 AM 頁面65



17:223
Уураа урвуулж хайраар дар
Улмаар хорслоо энэрлээр дар
Хуурах санаагаа үнэнчээр дар
Хувхай хармаа өглөгчөөр дар.

17:224
Үргэлж үнэнийг өгүүлж явах нь
Үнэхээр уураа барьж чадах нь
Тэгээд дээр нь өглөгч байх нь
Тэнгэрт төрөх гурван шалтгаан.



17:226
Өдөр шөнөгүй хичээн зүтгэж
Өглөө үдэшгүй санаж сэрж
Өнөд амгаланг зорин сурагсад
Өөдлөн гэгээрэх нь хэзээд гарцаагүй.



17:227
Аврагч гэгээн Бурхан Будда
Атулла шавьдаа ийн айлдвай:

Дуу цөөтэй нь хэлдэггүйгээр бууутна
Дуугарч хэлсэн нь чалчаагаар бууутна
Дориухан яривал ихэрхсэнээр бууутна
Доройхон үглэвэл ноомойгоор бууутна.

Энэ хорвоод бууутдаггүй хүнийг
Эрээд хайгаад олохгүй гэжээ.

MO016內 2011/3/23 02:01 AM 頁面66

17:228
Үргэлж сайнаар магтуулагч хүн
Үргэлж муугаараа дуудуулагч хүн
Урьд өмнө байгаа ч үгүй
Улмаар хойшдаа байх ч үгүй.



17:231
Алд биедээ эзэн шиг эзэн бол
Алдас хилэнгээс тойруулж гар
Алдаа нүглээс хол явуул
Арцун буяны замаар оруул.

MO016內 2011/3/23 00:56 AM 頁面67

17:229
Харин мэргэдэд магтуулж байдаг
Харш зэмээс нь ангид явдаг
Эрдэмтэй буянтай сэхээрэлтэй
Ийм сайчуул бас байдаг аа.



17:230
Эрхэм гэгээдийн магтаал болсон
Эсрэн тэнгэрүүдийн сайшаал хүртсэн
Эгэлгүй тэр сайчууд болбоос
Эргээс олдсон шижир мэт ээ.



17:232
Хэл яриандаа эзэн бол
Хилэгнэн аашлахаас сэрэмжилж холдуул
Хилэнцтэй үгийг битгий хэлүүл
Хэзээд сайныг яриулж сурга.

17:233
Өөрийн сэтгэлдээ эзэн бай
Өшөрхөл хорслоос цэвэрлэж бай
Өнөд бурууғаас цэрвүүлж бай
Өгөөмөр буян руу чиглүүлж бай.

17:234
Амь биедээ эзэн болж
Ам хэлээ захирч номхолж
Сэтгэл оюунаа сэрэмжлэн баригчид
Сэхээрэгч мэргэдийн оройн чимэг.

MO016內 2011/3/23 00:56 AM 頁面68

XVIII бүлэг

АРИУН БУСЫН ЦОМОРЛОГ

18:235
Хатсан навч шиг хөөрхий чам руу
Халаг хоохой, эрлэг айсуй
Хаана ч хүрэх аяганы хийцгүй
Харин эрлэгээс л зайлах замгүй.

18:236
Өөрийн биеийг гэмүүдээс таслаад
Өнө мөнхийн сэрэмжээр батлаад
Өнчин далайн арал болговол
Өмнө чинь диваажин нээгдэх болно.

18:237
Амьдрах хугацаа алавхийн өнгөрөөд
Аюулт үхэл тосоод авлаа
Амсхийх хүлээх хугацаа байхгүй
Амиа зогоох хүнс ч байхгүй.

18:239
Уран дархан төмрийн баасыг
Урлангаасаа үргэлж цэвэрлэж цэмцийнэ
Ухаант хүн гэмээ багаас нь
Ухаж арилгасаар төгөлдөр болно.

MO016內 2011/3/23 00:57 AM 頁面69

18:238
Алд биеэрээ орчлонгоос салаад
Ариусал гэгээрлийн арал болтугай.
Ад зэтгэр нь угаагдаж хийсээд
Аврагдаж нирваанд хүрэх болтугай.

18:241
Журам алдвал буян байвч буян болохгүй
Нурсан бол оромж байвч оромж болохгүй
Залхуу бол удам байвч удам болохгүй
Сэрэмжгүй бол амгаланг хүсэвч амгалан болохгүй.



18:242
Самуун садар явдал бүсгүй хүнийг баллана
Санаанд харам байвал өглөг буяныг баллана
Саар нүгэл хийвэл энэ ба хойдохыг баллана.

18:240
Төмрийн зэв төмрөө иднэ
Хүний алдаа эзнээ иднэ.



18:243
Муу нүглийн эх нь мунхаг тэнэг байдал
Муудаж осолдохын эх нь ч мунхаг тэнэг байдал
Мунхаг тэнэгээсээ л салбал бусад нь аандаа болно.

MO016內 2011/3/23 00:57 AM 頁面70







18:247
Архи дарсанд автаж ороод
Аж төрлөө гаргуунд хаягч
Амь амьдралаа сүйтгэж хаяна.

18:248
Салан палан тэвчээргүй хүмүүс
Саар нүгэлд амархан унана
Санаархал шуналаа татахгүй явбал
Сайнаас холдож зовлонд ойртоно.

18:249
Олдох өглөг, таарах хишиг
Оноосон үйлээрээ ихтэй, багатай
Ондоо хүнийхтэй зүйрцүүлж дүйцүүлж
Олсноо чамлавал амрахгүй тамтай.

MO016內 2011/3/23 02:10 AM 頁面72



18:250
Олдох тааралаа чамлах сэтгэлийг
Онхид тасдаад хаяж чадвал
Одоо ч маргааш ч өнөд амгалан.



18:251
Хүсэх тачаах шиг түймэрдэгч үгүй
Хүсэл шунал шиг түйтгэрлэгч үгүй
Хорсол занал шиг сүйтгэгч үгүй
Хоосон төөрөгдөл шиг сүйрэл үгүй.



18:254
Агаар тэнгэр мөр үгүй
Авсан ухаарал шиг аврал үгүй
Эрх чадалтнууд хийсэндээ баясна
Эрдэмт мэргэд гэгээрэлд баясна.

MO016內 2011/3/23 00:57 AM 頁面73



18:252
Бишдийн гэмүүд томорч харагдавч
Биеийнхээ гэмийг тодруулах амаргүй
Хүний гэмийг илтэд жигшинэ
Хувийнхаа гэмийг илэрхий нууна аа.

18:253
Хүний алдааг эрэхийн хэрээр
Хүзүүгээр татаж гэмүүд чинь өснө.



18:255
Тэнгэрээр нисэгчид мөр үгүй
Тэнэглэлээсээ салах шиг аврал үгүй
Тэр ч энэ ч бүгдээрээ хувьсана
Тэгэхэд үлдэх нь Буддагийн гэгээрэл.

MO016內 2011/3/23 00:57 AM 頁面74

XIX бүлэг

ҮНЭНЧ ШУДАРГЫН ЦОМОРЛОГ



19:256
Хэрэг явдлыг зоргоороо шүүгчид
Хэлмэгдүүлж, гүжирдэж хуулиас гажина.
Худал, үнэний ялгааг ологчийг
Хуулийг бариимтлагч шударгуу хэмээнэ.



19:259
Бурханы ном сургаал судраас
Бурсан болгон ухаарсан байдаггүй
Багахан үнэнийг зөвөөр сэхээрээд
Бариимтлан дагавал л номтой хүн ээ.

19:257
Үнэн худлын дэнс барьсан
Үнэнч шударгуу хууль баригч
Хэзээ ч өөрийн дураар шүүхгүй
Хэлмэгдүүлж хэнийг ч гүжирт хийхгүй.

19:260
Буурал толгойтой хөгшин болгон
Буян хураасан өтгөс бус аа
Зөв мөрийг олохгүй тэнэсээр
Зөнөсөн өтлөсөн нь нэг бус аа.

19:258
Уран цэцэлсэн яриатай болгон
Ухаан цэцэн мэргэд байдаггүй ээ
Ухаалаг сэрэмжтэй, бас элэгсэг
Улмаар айдасгүйг л ухаантан гэдэг ээ.

19:261
Үнэхээр гэм ба хороосоо салсан
Үнэн элбэрэлт буяныг үйлдсэн
Үлэмж сэтгэлээ номхотгогч өтгөс
Үгийг нь дагуушатай мэргэд мөн өө.

19.262
Хүний намба, царай тунгалаг ч
Хүүрнэх үгс нь сэтгэл татмаар ч
Хорсол, атаа, шуналтан байвал
Хоймор залах хүндтэн биш ээ.

19.263
Хорсол атаанаас салсан бол
Хортой шуналаа гээсэн бол
Хог шиг тэднээсээ салсан бол
Хоймортоо залуушатай мэргэн мөн өө.



19:264
Шанх үсээ хусуулж мулзайж
Шар, улаанаар хувцаслаж хувиравч
Шагшаабадаа сахихгүй л болбол
Шашныг бадруулах хүвраг бус аа

Ам хэлний нүглээсээ салалгүй
Авах эдлэхийн шуналаа гээлгүй
Амьтныг хорлох хилэнгээ хаялгүй
Авралын замаар яахин орох вэ.

19:265
Гэм нүглүүдээс бага гэлтгүй
Гэтэлж салагчид мэргэн бөгөөд
Гэтэлж нүглээс салахын хэрээр
Гэгээн хувраг тэр болно оо.



19:266
Сүсэгтний өглөгөөр амьдардаг болохоор нь
Сүм бараадагчийг ламтан гэдэггүй ээ
Сайн номд бүрнээрээ ороод
Сахилаа дагагчийг л ламтан гэдэг ээ.

MO016內 2011/3/23 02:20 AM 頁面76



19:267
Эгнэгт нүгэл буяныг ертөнцөд ялгаж орхиод
Энэ хорвоогийн явдлыг сайн буянд урвуулаад
Эрхэм дээдийн номоор гэгээрэн гэгээрэн ариусагч
Эгнэш үгүй, олдош үгүй хувраг багштан мөн өө.



19:268
Бодлогоширч дуугүй суугаад суугаад
Богино ухаантан мэргэн болдоггүй
Бодол санаагаараа цэгнэж, жинлэж
Бохир ба ариуныг тунгаагч л мэргэн.



19:270
Алаачин хэзээ ч буянтан байгаагүй
Аврагч л үргэлж буянтан байдаг.





19:269
Бохир ба ариуныг сэтгэлдээ тунгааж
Болох ба болохгүйг сайтар салгаад
Авах гээхээ ялган чадагч л
Ариун явдалт мэргэн болно.



19:271
Дан гагч сүсгээр хүрэхгүй
Дан цээжилсэн номоороо хүрэхгүй
Дан хатуу сахилаараа хүрэхгүй
Даамай баясгалан Буддад байдаг аа.



19:272
Аглагийн даяанаар хүрээгүй нирваанд
Амралтгүй бясалгаад үзээгүй нирваанд
Арилгаж нүглээсээ салахын цагт л
Аврагдаж очих нигууртай юм шүү.

MO016內 2011/3/23 02:20 AM 頁面78

XX бүлэг

ЗАМ МӨРИЙН ЦОМОРЛОГ





20:273
Үзтэл мөрийн дээд нь хутагтын найман зам
Үнэн мөний дээд нь хутагтын дөрвөн үнэн
Эдлэх жаргалын дээд нь хүсэх шунахаас салах
Эрх хүчний дээд нь оюуны мэлмий нээгдэх.

20:274
Оюуны мэлмийг нээх зам мөр ганцхан бий
Ондоо хаагуур явсан ч тийшээ очиж чадахгүй
Онхид салаа салбаргүй билгийн замаас гадуур
Отон хорлохыг санаархагч шулмын зөрөг бас бий





20:277
Бүтсэн хурсан хорвоогийн юмс
Бүгдээрээ хувиран хоосонд урвана
Бүх юм хоосныг ухаарсан хүн
Бүтэхэд, арилахад зовохгүй амгалан

Аврал гэгээрэлд хөтөлж хүргэх
Арцун гэгээн мөр зам энэ ээ.



20:275
Гагцхүү энэ л замыг дагаснаар
Гай зовлон, эцэслэж аврагдана
Гай зовлонгоос аврах энэ мөр
Гарцаагүй миний номлосон зам мөр өө.

20:276
Үнэнхүү шамдах юм авралын мөр мөн
Үнэхээр замчлагч нь Будда багш мөн
Үзтэл хорлогч шулмын зангаанаас
Үлэмж гэгээрэл, бясалгалаар мултарна.



20.278
Бүтсэн хурсан хорвоогийн юмс
Бүгд урваад зовлонд хурдаг аа
Бүтсэн хурсны зовлонг танигчид
Бүтэх хурахад зовохгүй амгалан

Аврал гэгээрэлд хөтөлж хүргэх
Ариун гэгээн мөр зам энэ ээ.

20:279
Бүтсэн хурсан хорвоогийн юмсын
Бүрхэх хэлбэрт өөрийн чанар үгүй
Бүгдээрээ өөрийн чанаргүйг танигчид
Бүрхэх хэлбэр нь урвахад зовохгүй

Аврал гэгээрэлд хөтөлж хүргэх
Ариун гэгээн мөр зам энэ ээ.

MO016內 2011/3/23 00:57 AM 頁面80



20.280
Эрхийдээ чадалтай идэрхэн явлаа ч
Эр зориг тонгорог шиг байлаа ч
Эртэлж мэрийдэггүй, залхуу аваас
Эрхэм сайн зам мөрт орохгүй ээ.



20:283
Айдас, шунангуйн модыг бус
Авах шунахуйг ойтой нь түймэрд ээ
Нүглийн ширэнгэ цурам болоход л
Нүглээс хуврагууд салах билээ.



20:281
Сэрэмжгүй чалчин хэлний гэмийг эгнэгт хийхгүй
Сэтгэлдээ хорсон бодол санаандаа хилэнц тээхгүй
Алд биеэр үйлдэх нүглийг хорин чандалж чадагч бол
Аврал буяны зам мөрийг олон хөвгч мөнөөс мөн өө.



20:282
Бясалгах хэрээр билэг хөгжинө
Бясалгахаа боливол билэг буурна
Бясалгал ухаарлаа улам хөгжүүлж
Баясгалант зам мөрийг дага аа.

20:284
Эмсийн шуналыг багахан дээр нь
Эртхэн тасалж хаяхгүй юм бол
Эхийгээ гувших ховдог тугал шиг
Энэ хорвоогийн хүсэлд татагдмуй.



20:285
“Намайг” гэдэг аминчлалын дэлбээг
Намрын навч шиг тасчин хаяад
Нирваанд хөтлөх Бурханы чигийг
Насан туршийн зам мөр болго.

MO016內 2011/3/23 00:58 AM 頁面82



20:286
Өвөл зунгүй энд л тухалж
Өнөд суух юм бодоод явагч
Өөрийг нь отогч үхэл зовлонг
Өнгөрөөх юм шиг андуурч суумуй.



20:287
Унтаа хотыг уулын үер
Урвуулж урсган хамах мэтээр
Ураг сандаа хайртай байлаа ч
Угтах үхэл хагацуулж авна.



20:288
Хайртай байлаа ч үхэл ирэхэд
Хамаатан ах дүүс хаах нь үгүй
Эрлэгийн элчийн аяыг аргалж
Эргүүлж явуулах садан үгүй.

MO016內 2011/3/23 00:58 AM 頁面83



20:289
Сахил, номоо үнэн баримтлаад
Сайн явдлаа гэгээрлээр чимээд
Салахгүй отогч аюулыг танигчид
Сансраас хагацаж нирваанд очно.

MO016內 2011/3/23 00:58 AM 頁面84

XXI бүлэг

ХЭСЭГ БУСГИЙН ЦОМОРЛОГ

21:290
Өнийн их жаргалын төлөө
Өнөөгийн жаахан жаргалыг золино.
Өгөөмөр дээд нирвааныг зоригч
Өчүүхэн багад сатаарахгүй цаашилна.

21:291
Өөрийн жаргалыг хөөж явахдаа
Өрөвлийг жаргалаас хагацааж хорловол
Өчнөөн дайсан замаас төрж
Өнөд зовлонтой барилдаж үлдэнэ.





21:292
Хийгүүштэй чухлыг хойш нь тавиад
Хийшгүй бурууг ийн хойноос хөөвөл
Хэлшгүй худлаар хэнэггүй явбал
Хэзээд хилэнц арвидаж зузаарна.



21:293
Хийгүүштэй чухлыг эрхэмлэн үйлдээд
Хийшгүй бурууг аас эмээн тойроод
Хэзээд сэрэмжтэй, хичээлтэй явбал
Хилэнц нүгэл нимгэрч арилна.

21:294
Бардамнал-аавыг, шунал-ээжтэй
Барьж алахад нүгэл байхгүй
Байгаа гэх ба үгүйсгэл-ноёдыг
Баривчлан устгахад гэм байхгүй

Орчлонгийн хүлээс-гүрэн улсыг
Оргүй мөхөөхөд цааз байхгүй
Ийм аллага, тийм хядлагад
Эргэж хэлэлцэх ял гэж байхгүй.

21:295
Бардамнал-аавыг шунал-ээжтэй
Байгаа гэх ба үгүйсгэл-ноёдтой
Нирвааанаас холтгогч “таван бар”-ыг
Нийлүүлж хөнөөгөөд зовлонгоос сал.

21: 296
Гэгээн Буддаг шүтэгч хүмүүн
Гэрт гадаагүй сэрэмжилж, ухаарна
Гэгээн өдөр ч, харанхуй шөнөөр ч
Гэгээн Будда сэтгэлд нь хадаастай.



21:297
Гэгээн Буддаг шүтэгч хүмүүн
Гэрт гадаагүй сэрэмжилж, ухаарна
Гэгээн өдөр ч харанхуй шөнөөр ч
Гэгээрүүлэгч номлол-Дармаг баримтална.



21: 298
Гэгээн Буддаг шүтэгч хүмүүн
Гэрт гадаагүй сэрэмжилж, ухаарна
Гэгээн өдөр ч харанхуй шөнөөр ч
Гэгээрэлд хөтлөгч багш-Сангаг дагана.

21:299
Гэгээн Буддаг дагагч хүмүүн
Гэрт гадаагүй сэрэмжилж, ухаарна.
Гэгээн өдөр ч, харанхуй шөнөөр ч
Гэмээс үргэлжилж сэрэмжилнэ.

21: 300
Гэгээн Буддаг дагагч хүмүүн
Гэрт гадаагүй сэрэмжилж, ухаарна
Гэгээн өдөр ч, харанхуй шөнөөр ч
Гэгээрэл нигүүсэл, энэрэхүйд суралцана.



21:301
Гэгээн Буддаг дагагч хүмүүн
Гэрт гадаагүй сэрэмжилж, ухаарна
Гэгээн өдөр ч, харанхуй шөнөөр ч
Гэгээрүүлэгч бясалгалд баясан шамдана.

21:302
Ертөнцийг орхиод явчихад бэрх
Ертөнц дээрээ жаргахад ч бэрх
Аглаг хийдэд шавилахад ч бэрх
Айл гэр болоод амь зуух ч бэрх

Ханилж нэгэнтэй хамтрах ч бэрх
Хаячихаад ганцаараа хэсүүчлэх ч бэрх
Учир утгагүй эрлээ хаяхад
Уйтгар зовлон хамтдаа зогсоно.

21:303
Ариун явдлаар замнал хийгээд
Аврал нигүүлсэл, шударга, үнэнчээр
Алдраа хийсэн тэр хүмүүн
Аль ч газарт хүндлэгдэж явна.



21:304
Ариун үйлс далдуур байлаа ч
Алтайн оргил шиг илэрхий тодорхой
Хажууд байсан ч муу явдал
Харанхуйд байх мэт үзэгдэхгүй
балархай.

21: 305
Орь ганцаар аглагт сууж
Орь ганцаар амарч нойрсож
Орь ганцаар алхан бядаж
Ойн гүнд даяанчлан суугч
Огтоос зовлонгүй цэнгэл амсана.

MO016內 2011/3/23 00:58 AM 頁面86

XXII бүлэг

ГАСЛАНГИЙН ЦОМОРЛОГ

22:306
Эс болсныг худлаар яригч
Эсвэл болоогүйг болсноор мэлзэгч
Энэ хоёр ялгаа байхгүй
Ирэх төрөлдөө тамд унана.

22:307
Лавтай энэрэхүйг эзэмшээгүй ахул
Лавшруулж сахилаа дагаагүй ахул
Лайтай хилэнцээсээ салаагүй ахул
Лам байлаа ч тамдаа л унана.

22:308
Улс амьтны өглөгт шунасан
Уг араншин нь хүнээ байсан
Халаг хоохой оронцог явснаас
Халуун ширэм залгих нь дээрсэн.

22:309
Хүний ханьтай нууцалж нөхцөөс
Хүндлэл үнээ алдаж зовно
Амьтнаас ичиж, хочлуулж зовно
Адаг сүүлд нь тамд унана.



22:310
Бачимхан зуурын цэнгэлд амтшиж
Бусдын янагтай нөхцөн явалдваас
Бахархах нэр, амьдралаа сүйдэлж
Бас дээр нь шийтгэл амсана аа.

22:311
Гүша өвсийг сэрэмжгүй баривал
Хүрсэн газраа огтолж эсгэнэ
Гүн даяанд ч журам алдвал
Гүнзгий тамд унаж зовно.



22:312
Ажил үйлээ сэрэмжгүй орхиод
Аугаа завшаанаа тоолгүй суллаад
Ариун сахилаа тоосонд хаявал
Аюус тамд унахгүй хаачихав.

22:313
Алив үйлийг эхэлсэн л болбоос
Араас нь ханцуй шамлан зүтгэ ээ
Ажиггүй хойрго, хэнэггүй хүний
Ажил үйлс замхарч дуусдаг аа.

22:314
Алив нүглийг хийсэнд орвол
Алгасаж тойроод явсан нь дээр шүү
Ач буяныг л үйлдээд явбал
Алсдаа ямар зовно гэх биш.

22:315
Оромж цайзыг биедээ байгуулж
Орох гарах хилэнцийг чандал
Осол цалгаргүй ямагт хичээж
Олдох боломжийг алдахгүй ашигла.

22:316
Ичмээргүй юмнаас дөлдөг хүн
Ичгүүртэй юм руу дөхдөг хүн
Алдаж эндэж бурууд унана
Авралаа алдаж тамд зовно.



22:317
Аймгүй юмнаас дөлдөг хүн
Аймшгийн юм руу дөхдөг хүн
Алдаж эндэж бурууд унана
Авралаа алдаж тамд зовно.

22:318
Зөрүү бурууг зүйтэй мэт сэхээрэгч
Зөв сайныг зөрүүлэн ухаарагч
Алдаж эндэж бурууд унана
Авралаа алдаж тамд зовно.



22:319
Бузар хилэнцийг буруу гэж мэдэгч
Буянт явдлыг буянаар нь танигч
Алдахгүй эндэхгүй, бурууд унахгүй
Амгалан жаргаланд хүрч дээшилнэ

MO016内 2011/3/23 02:36 AM 頁面88

XXIII бүлэг

ЗААНЫ ЦОМОРЛОГ

23:320
Хамаг биеийг нь харваж сэглэхэд
Хатуужин даадаг цэргийн заан шиг
Хатуу доромж үгсийн шархыг
Хатуужил тэвчээрээрээ би давна.



23:321
Уналга эдэлгээнд дассан зааныг
Унаж хаантан морилохдоо хавтай
Учир таньсан номхон мэргэд
Уур хилэнтнийг тоохгүй нь бахтай.



23:323
Номхон луусаар нирвааид очихгүй
Номхон ажнайгаар нирвааид очихгүй
Номхон заанаар ч нирвааид очихгүй
Номхорсон сэтгэл л диваажинд хүргэнэ.

23:324
Олзонд хоригдсон Данапаалка заанд
Ойгоос өвөр мөрөөдөл үгүй
Оосор уягаа тэсгээх ч үгүй
Оволсон өвсөнд сатаарах ч үгүй.

MO016內 2011/3/23 02:36 AM 頁面89



23:322
Хүчрийг үүрэгч лууснаас номхон дөлгөөн нь гайхамшиг
Хүлэг морин дотроос Синди ажнай гайхамшиг
Хүчтнийг залагч дундаас зааныг хөтлөгч гайхамшиг
Хүний ертөнц дотроос сэтгэлээ захирагч нь гайхамшиг.

23:325
Ховдог болоод сэрэмжгүй хүмүүн
Хогоор тэвээрэх гахайтай адил
Унтаа болоод нойрмог түүний
Урдах замнал зовлонд эргээстэй.

MO016內 2011/3/23 02:41 AM 頁面90



23:326
Эмнэг зааныг сургаж аваад
Эдэлж зоргоороо хөтлөх мэтээр
Эрх зоргоор сэтгэл санаагаа
Эндээс хойш жолоодож зална аа.

23:327
Уулын жалгад намагт суусан ч
Ухасхийн гардаг тэнхээт заан шиг
Сэтгэл санаагаа сэрэмжээр хамгаалж
Сэвтээгч гэмүүдийн намгийг гэтлэ.

23:328
Хэрсүү болоод сэрэмж төгөлдөр ховор сайн нөхөр
Хэрвээ чамд заяаж учирваас түүнээсээ салалгүй
Хэрэм цайз мэт хөндөлдөх зовлонг хамтдаа гэтлээд
Хэзээд зол завшаан төгөлдрөөр одогтун.

23:329
Хэрвээ сайн нөхөр хань эрээд эрээд эс таарваас
Хэн нэгийг хань татаж түвэг битгий удаарай
Хэзээд дийлсэн орноо орхигч хаад ба ойд ганцаараа
Хэрэн одогч зааны үлгэрээр ганцаарчлан одогтун.



23:330
Алмай тэнэгтэй ханилсанд орвол
Амь амиа л бодсон нь ононо оо
Аглаг хөвч рүү заан мэт шилэрвээс
Аливаа шунал, хилэнцээс холдоно оо.

23:331
Зовох цагт сайн нь мэдэгдэх нөхөр хань энэ нэгэн баясгалан
Зол учралаар дүүрэн жаргалант сэтгэл мөн нэгэн баясгалан
Зорьж үйлдэж хураасан буян нь үхэхийн цагт
өнөө төрлийн баясгалан
Зовлонг таньж амирласан амгалант гэгээн сэтгэл
өнө мөнхийн баясгалан.

23:332
Ээжийн энэрлийг эргүүлэн
ачлах үр болсны жаргалан
Эцгийн хайрыг өргөн хариулах
үндэслэж ургасны жаргалан
Эрхэм буяны замаар орох
хүний төрөл олсны баясгалан
Эрдэмт гэгээрлээр нирваанд
хүрэх өнө мөнхийн баясгалан.

23:333
Нүүрэндээ буянтай өтлөх намбалаг өтгөс жаргалтай
Нүглээс хагацаагч сахилаа өнөд баримтлагч жаргалтай
Хорт хилэнцээ орхин, шуналаасаа хагацагч жаргалтай
Ховор завшаант гэгээрлээр баясгаланг танигч
жаргалтай.

MO016內 2011/3/23 02:48 AM 頁面92

XXIV бүлэг

ШУНАЛЫН ЦОМОРЛОГ



24:334
Осол цалгар, сэрэмжгүй хүнийг
Ороонго өвс шиг шунал нь хүлнэ
Модноос модонд үсчин жимсчлэх
Монди бич шиг төрлүүд дамжина.

24:335
Чимх төдий ч шунал
багадахгүй
Чиний амгаланг эзэлж эвдэнэ
Чийг авсан өлөн өвс шиг
Чимээгүй ургаж хучин авна.



24:336
Дайсан болсон хорт шуналыг
Даран ялагч л баатар бөгөөд
Навчис шүүдрээ гөвөх мэтээр
Нажид зовлонгоо сэгсэрч хаяна аа.

24:337
Чихээ нааш нь тавиад сонс
Чин үнэнийг хэлээд өгье?
Тарьсан ногоогоо хураахын тулд
Тайрах биш үндсийг ухна
Тачаал шуналаас хагацахад тэр мэт
Тайрах бус ёзоорыг тасална.

Эрэг газрыг модтой юутай
Эмтэлж урсах уулын үер мэт
Энэ насыг зовлонгоор холтлогч
Элдэвлэн хорлогч шулмаас сална.

24:338
Үзүүр мөчрийг тайраад тайраад
Үндэс нь байвал ургаад байдаг
Цадахгүй шуналын үр нь байвал
Цагдаж сэрэмжлэвч ундраад
байдаг

Ундарч эзэмдсэн шуналын үрээр
Улмаар чи зовлонд эргэлдэнэ.

24:339
Ертөнцөд шунах хүслийн
гучин зургаан мөрөн
Ерийн гэнэн хүнийг урхидан
живүүлж одно оо
Авах шунахын үерт хөл алдан
одогчийг
Амьдын тамаар эргэлдэх хүрхээ
цүнхээлд аваачна.

24:340
Хүсэл шуналын уруй хаашаа ч үерлэх магадтай
Хүй нэгтэй ороонго нь хаанаас ч дэгээдэх аюултай
Хаанаас ч отож мэдэх аюулт ороонгын үндсийг л
Хамаг оюунаа дайчлан эрж олоод огтлогтун.

MO016內 2011/3/23 02:41 AM 頁面93

23:341
Хүсэл шуналын илбэ урхин
Хүний сэтгэлийг илбэж хуурна
Хүслийн тэр илбээсэнд унахад
Хүрдлэн эргэх зовлонд уягдана.

24:342
Хомхруус буудайнд хорхой хөдлөөд
Ховдог туулай занганд унавай
Хорт шуналын амтанд унаад
Хорвоогийн зовлонт хүрдэнд эргэвэй.



24:343
Занганд хууртсан туулай урхинд
үлдэх мэтээр
Завших шуналын өгөөш
орчлонгийн хүрдэнд уяна
Тачаах шунахаа хорьсон гэгээн
явдалт хувраг нь
Тамын үүд рүү хөтлөгч хүслийн
хүлээсийг тайлна.



24:344
Хүсэл шуналын ширэнгээс
зугтаж чадсан атлаа
Хүний ертөнцийн зовлонгоос
дайжиж гарсан атлаа
Ахуй ертөнцийн цэнгэлийн
амтанд эргэн дурлаж орогч
Анжсаа үгүйлэгч шар, чөдрөө
мөрөөсөгч морин мэт.

24:345
Төмөр гав, олсон уяа, модон
тушааг
Төгөлдөр мэргэд хатуу бат хүлээс
гэдэггүй
Төрсөн үр, янаг эхнэр, хураасан
зөөсөнд уягдах сэтгэл л
Төмөр, ган ямар ч хүлээсээс хатуу
чанд аргамж байдаг аа.

24:346
Ухаант мэргэд энэ хүлээсийн
Урхидагч амт илбээсийг таниад
Учгийг татан өөрийгөө суллаж
Ужид цэнгэл, шуналаас хагацна.

24:347
Авах хүслийн үерт живэгсэд
Аалзны тор шиг хүлээсэнд эргэлдэнэ.
Төөрөгдлийн энэ тор ба үерээс
Төгөлдөр мэргэд л чөлөөлөгдөж гарна.

24:348
Өнгөрсөн төрлүүдийн нүглээ наманчилж ариусгаад
Өнөө гэгээрсний үрээр маргаашийн гэмүүдийг хаагаад
Өнхрүүлэн эргэх орчлонгийн хүрднээс ашид мултран
Өнөд ариусаад хүлээсээс мултарч бодисадва болно.

24:349
Хүсэл шуналын зэрэглээ хоосон диваажинг зураглаад
Хүний сэтгэлийг илбэдэн, улам шунал төрүүлнэ
Хүсэл улайрахын хэрээр шуналын гал арвидаж
Хүлж агдлан бариад орчлонгийн хүрдэнд төдөрлөнө.



24:350
Сэрэмж төгөлдөр аваас шунах хүсэх хаагдаж
Сэтгэлдээ амгаланг бясалгаж чөлөө учралыг олоход
Шуналын чөдрөө бариад хөлд суухыг санаархагч
Шуламын гарыг хугачаад хүлээсээс өөрийгөө чөлөөлнө.

24:351
Авах шуналаас ангижирагчийн бие
Алах омгийг алгасрагчийн бие
Айх гэмүүдээ арилгагчийн бие
Амгаланг эгнэгт ологчийн бие

24:352
Үйлийн үрийг үнэнхүү таньсан
Үзтэл номыг зөвөөр нь тайлсан
Үг үсэгчлэн явдлаа болгосон
Үлэмж гэгээрлийг замналаа байлгасан

Огтоос шуналгүй тэрний бие
Орчлонд байх сүүлчийн бие.

24:353
Үзье гэхнээ шунал хүсэл байхгүй байна
Үнэн аюулт сэтгэлийн гэмүүдээ дарсан байна
Үлэмж гэгээрэн тэгш амгаланд хүрсэн байна
Үймээнт хорвоогоос нэгэнт ангижран салсан байна.

Орчлонгийн үнэнийг таньж номлоход хүрсэн байна
Олон амьтныг зовлонгоос аврагч болсон байна
Оргилд гарч олдошгүй нирваанд хүрсэн байна
Одоо намайг багшлан замчлагч хаана ч үгүй ээ.

24:354
Өглөг бэлгийн дээд нь номын өглөг болно
Өег амттаны дээж нь номыг амтлах болно
Зол баяслын дээд нь номд баясах болно
Зовлон гачаалаас гаргаж, шулмыг дардгаас тэр.

MO016內 2011/3/23 00:59 AM 頁面95



24:355
Эрдэнэ баялаг мунхагуудад лай
Эвдэж сэтгэлийг хөнөвгч гай
Авах хураахын дон аазгай нь
Амиа хорлох мэт өөрийг нь хөнөөнө.

24:356
Будаа тарианы ургац талбайг
Буйлсан шарилж хэрж иднэ
Будангуй санал, тачаах шунал
Буяны замыг барж иднэ.

Хүсэл тачаалаас салсан буянтанд
Хүргэсэн өглөг л буян хураана.

24:357
Будаа тарианы ургац талбайг
Буйлсан шарилж хэрж иднэ
Ухаан муутын амны хишгийг
Уур хорсол нь урж иднэ.

Атаа хорслоос салсан буянтанд
Аваачсан өглөг л буян хураана.

24:358
Будаа тарианы ургац талбайг
Буйлсан шарилж хэрж иднэ
Муу хүний хувь заяаг
Мунхаг харанхуй нь алж иднэ

Алмай мунхагаас салсан буянтанд
Аваачсан өглөг л буян хураана.

24:359
Будаа тарианы ургац талбайг
Буйлсан шарилж хэрж иднэ
Хүсэх шунах хорвоогийн гэм
Хүний заяаг барж иднэ.

Хүсэх шунахаас салсан буянтанг
Хүндэлсэн өглөг л буян хураана.

MO016内 2011/3/23 00:59 AM 頁面96

XXV бүлэг

ХУВРАГИЙН ЦОМОРЛОГ

25:360
Үзэж харахаа хянан чадвал гайхамшиг
Үргэлж сонсохоо хянан чадвал гайхамшиг
Үнэртэж мэдэхээ хянан чадвал гайхамшиг
Үгээр ярихаа хянан чадвал гайхамшиг.

25:361
Алд биеэ захирч чадваас сайн
Ам хэлээ захирч чадваас сайн
Өөрийн сэтгэлийг захирч чадвал сайн
Өөр бусад юм бүхнээ захирч чадвал сайн

Өөрийн сэтгэлийг чандалж захирсан хүвраг
Өнөд хилэнцээс салж, хорвоогоос зовлонг гэтэлнэ.



25:362
Хүрэх гараа чандлан мэдэх чухалтай
Хүргэх хөлөө чандлан мэдэх чухалтай
Үг хэлээ чандлан мэдэх чухалтай
Үнэн сэтгэлээ чандлан мэдэх чухалтай.

Сэтгэлээ хянаж, амгаланг бясалгагч
Сэрэмжит хүвраг л хорвоог гэтэлнэ.



25:363
Ам хэл ухаалаг цэгцтэй
Амгалан тайван зан төрхтэй
Ариун номыг үнэнхүү ухаараад
Айлдан сургагч л хүвраг мөн өө.

25:365
Өөрт ногдохыг чамлаж болохгүй
Өрөөлийн хувьд атаархаж болохгүй
Атаач сэтгэлээ хаяагүй цагт
Авралт Самадийн гэгээрэлд хүрэхгүй.

25:364
Ариун хүврагууд номд дурлаж
Арвин утгыг нь тайлан баясч
Ахиухан ухаарч гэгээрэхийг хичээж
Алхам бүрдээ номтой нөхөрлөнө.

25:366
Жинхэнэ хүвраг бага нь ногдлоо ч
Жишиж атаархах зовлон байхгүй
Тэнсэх атаархах зовлонгүй хүврагийг
Тэнгэр нарууд ч сайшаан магтана.



25:367
Аминчлан үзэх “би”-гээс салсан
Аливаад хоргодох шуналаа гээсэн
Хорвоог эргэлдэхийн зовлонгоос уйдаж
Хоосон чанарыг танигч л хувраг аа.

25:368
Машид аврагч Бурханы сургаалд
Магнай тэнийж баясан гэгээрээд
Үйлийн үрийг үндсээр нь таслагч л
Үнэнхүү сайн хувраг мөн өө.

25:369
Усыг нь байнга шавхраад байвал
Унасан завь хөнгөн хурдан
Утгаж гэмүүдээ хаяад байвал
Үгтах гэгээрэл дөхүү ойрхон.

Атаа шуналын үндсийг тасдахаар
Аяндаа нирваанд хүрэхээр одно.

25:370
“Таван саад”-ын хүлээсийг огтолж
“Таван хүсэл”-ээс салж огоорч
“Таван буян”-ыг замналаа болгоод
“Таван саад”-аас салсан хуврагийг
Тамын аюулаас гэтэлсэнд үзнэ.

25:371
Хуврагууд минь, үргэлж бясалгаад
Хурамхан төдийд ч алдалгүй сэрэмжил
Урин хилэнцийн зэрэглээнд илбэдүүлж
Улайдсан ширэм битгий залги.

Халцгай, түлцгэйг нь мэдэж орилоход
Хамаг юм оройтсон байна шүү.

25:372
Оюун билэггүй бол бясалгал хийж чадахгүй
Огтоос бясалгалгүй билэг оюунтай болохгүй
Оюун билэг бясалгалтай хоршоод
Оройн дээд нирваанд хүргэнэ.

25:373
Амгаланг мэдрэгч өөрийн зайдаа
Амьтны үймээнээс холхон бясалгагч
Ариун номын амтыг мэдэж
Амсах цэнгэл нь хүнийхээс хэтийднэ.

25:374
Цогцсын мөхөл ба мөнх бусыг
Цогцоор ухаарах тэр хувраг
Үргэлж мөнхийн нирвааныг таньж
Үнэнхүү баясгаланг олдог юм аа.

25:375
Үнэн баясгаланг олохдоо хуврагууд
Үргэлж сахилтай тунгалаг аж төрж
Үнэхээр залхуугүй шамдалтай амьдарч
Үзтэл цэмцгэр ариунаар оршиж

Таван мэдрэхүй, сэтгэлээ хянаж
Тайван амирлангуйн цэнгэлийг амсч
Арван хуруу шиг андуудаа шүтэж
Арвин буяны мөрийг хөөгтүн.



25:376
Олныг ачилж, өргөж, түгээж
Олсон буян нь хэтийдсэн хувраг
Онцгой баясгалан дүүрэн амьдраад
Орчлонгийн зовлонг үүрд орхино.

25:377
Гүйлс мод хатсан навчсаа
Гүвж хаяад улам цэмцийнэ
Хүний дээд ариун хуврагууд
Хүсэл, омгоо гээж ариусна.

MO016內 2011/3/23 02:57 AM 頁面99

25:378
Үнэхээр ертөнцийг огоорсон хуврагийн
Үзэгдэх биеийн төрх амгалан
Өгүүлэн ярих үгс нь амгалан
Үлэмж чанадын сэтгэл амгалан.

25:379
Өсөж дэвжих сайн хуврагууд
Өөрийн явдлаа үргэлж хянаж
Өө, алдаанаас сэрэмжлэн зайлж
Өрөвхийх омгоо дарж номхолно.

25:380
Олдсон биеийг та хамгаалахаас хэн хамгаалаҳ
Оройлогч гэгээрэлд өөрийгөө л хөтлөхөөс хэнээр хөтлүүлэҳ
Осол гэнэдлээс өөрийгөө л аврахаас өөр хэнийг хараҳ
Омтгой хүлгийг унасан ээзн нь залахаас өөр хаанаас залаҳ.



25:381
Үнэн номын сургаалыг дагаж
Үнэхээр баясгаланг хүртэгч хувраг
Үйлийн үрийн хүлээсийг тасалж
Үлэмж нирвааНд одоож хүрнэ.

25:382
Үзтэл нас нь залуухан багаараа ч
Үнэнхүү шамдалт идэрхэн хувраг
Үүлнээс саран мултарч гийх мэт
Үйлт амьтсыг гийгүүлж тусална.

MO016內 2011/3/23 02:57 AM 頁面100

XXVI бүлэг

БЯРМАНЫ ЦОМОРЛОГ





26:388
Саар гэмүүдээс хагацсан бол тэр бярман байна
Санваар сахилаа дагасан бол тэр хувраг байна
Самуун хорлолт сэтгэлийн гэмээс салсан тэрээр
Сайн явдлыг баримтлагч, Бурхан багшийн шавь байна.

26:389
Гэгээн хувраг хүн рүү гар далайвал нүгэлтэй
Гэтэл үүний төлөө хорсох гэгээн ч нүгэлтэй
Ариун явдалт гэгээнийг жанчих нүгэлтэй байхад
Ариун бярман өөрөө жанчуулаад хорсвол нүгэлтэй.

26:390
Дурлах хүсэхээсээ салахын хэрээр
Бярманы жаргал нэмнэ
Хорлох сэтгэлээс холдохын хэрээр
Гэм арилж амгалан болно.

26:391
Үнэхээр бие, хэл, сэтгэлийн нүглийг
Үйлдэхгүй тэвчвэл тэр бярман мөн
Үлэмж хорт энэ гурван нүглийг
Үүрд тэвчигч тэр л үнэхээр бярман мөн.



26:392
Авралт бурханы номыг заасан
Ачлалт тэр багшийг хүндэл
Асаасан тахилдаа сүслэх бярман шиг
Аврaлд хөтөлсөн багшаа дээдэл.



26:393
Удмын гэргэтэн, язгуурын гэзэгтэн
Угаасаа л бярман байна гэж үгүй ээ
Ухаарсан үнэн, сэхээрсэн номтой
Улмаар ариун явагч л бярман юм аа.

MO016內 2011/3/23 03:16 AM 頁面102





26:394
Агсуулж чимсэн гэзэг хоосон толгойд юун?
Амьтнаас хуулж булаасан арьсан хувцас ч юун?
Хар хор, тачаангуйд сэтгэл буртагласан байхад
Харагдах гадна өнгөө чимээд юуны ашиг вэ?

26:395
Халхлах төдий эгэлдрэх юмтай
Хамаг судас нь гүрийсэн туранхай ч
Хаана ч хэн үймэхгүй аглагт
Хатуужин бясалгагч бярман мөн өө.

26:396
Удамт бярман ч гэгээн гэгдэхгүй
Угаас баянаараа ч бярман дээрдэхгүй
Угсаа хэргэм хөрөнгөө огоороод
Уур шуналаас салагч л бярман мөн өө.

26:397
Хорвоогийн хүлээсээс тайлагдаж
аврагдсан
Хортой сэтгэлийг таслаад амарсан
Хоргодох шуналаас тасраад
амирласан
Ховорхон заяатан нь бярман мөн өө.

26:398
Хорслын торыг эвдэлж гараад
Хорлонт шуналаас эгнэгт зайлаад
Буруу үзлийн хүлээсийг тайлаад
Бузар мунхагаас салагч бярман мөн.



26:399
Үгээр сөрж хэрүүл хийдэггүй
Үсдэж зодсон ч хилэн төрдөггүй
Үргэлж өршөөн, энэрэх сэтгэлт
Үнэхээр тэр хүн бярман мөн өө.

26:401
Зүсэр борооны дусал цэцгийн дэлбээнд тогтохгүй
Зүүний нэгэн үзүүрт буудайн үр тогтохгүй
Зүүний толгой хэрийн ч нүгэл тогтоохгүй хүнийг л
Зөв ариун явдалт бярман хувраг хэмээнэ ээ.

26:400
Элдэв хилэн, жөтөө атаагүй
Эдлэх хүсэл, авах шуналгүй
Энэлэх зовлонгүй амгалан сэтгэлт
Эргэлтгүй бясалган нирвааныг зоригч

Эцсийнхээ биеийг орчлонд элээгч
Эргэж төрөхгүй бярман мөн өө.



26:402
Одоо энэ төрөлдөө зовлонг төгсгөл болгоод
Орчлонгийн хүрдэнд эргэлдэх үхэл, төрлийг дуусгах
Оноо тавилан бүрдэж үйлийн үрээс салсан
Онож яваа тэрнийг бярман хэмээн нэрийдмүй.

26:403
Оноо алдааг ялгаж зөв бурууг танин
Оноож ялгах эрдэмтэй, гэгээн билгүүн ухаантай
Онооож дагасан замналдаа туйлгүй үнэнчээр хүрсэн
Онцгой тэр заяатан бярман хувраг мөн өө.



26:404
Хоргодох газар гэр нь болдог
Хуврагийн ч, харын ч хийд, булээс холуур явдаг
Хувь заяагаа орчлонгийн хүлээснээс тасалж авсан
Хутагтын явдалт тэр хүн бярман мөн өө.

26:405
Амьтныг зодож хорлодоггүй
Амийг нь тасалж хороодоггүй
Айлгаж ичээж зоводоггүй
Ариун явдалтан Гэгээн мөн өө.

26:406
Атаат дайсны дунд атал атаат дайсангүй явагч
Алан хядагчдын дунд атал мэсгүйгээр тайван оршигч
Авах хураахын дунд атал авахгүй шунахгүй тавиун суугч
Амгалан сэтгэлийг ологч тэрээр бярман мөн өө.

26.407
Ур тариа зүүний үзүүрт
Үнэхээр тогтохгүй мултарч унана.
Хосгүй бярман хүний сэтгэлд
Хорт санаа тогтохгүй унана.

26:408
Зөв үнэн яриа хэлтэй
Зөөлөн аядуу ая зантай
Зөрүү доромж аашаа гээгчийг
Зөвхөн бярман хэмээн нэрлэнэ.

26:409
Өндөр намаар голж шилдэггүй
Өргөн нарийнаар гоочилж хардаггүй
Өөрт ногдоогүй юуг ч авдаггүй
Өгөөмөр тэр хүн бярман мөн.

MO016內 2011/3/23 03:16 AM 頁面105

26:410
Энэ төрөлдөө шунасан юм байхгүй
Ирэх төрөлдөө ч шунах юм байхгүй
Эгнэгт шуналаа тасалсан тэр хүн
Эрхэм дээд бярман мөн өө.

26:411
Тачаал шуналаа тасалж хаясан
Таньсан ухаарсан төгс болсон
Хүсэхгүйн баясал, шунахгүйн жаргалд
Хүрсэн тэр хүн бярман мөн өө.

26:412
Хилэнгээс салсан, хилэнгээ хаясан
Хир толбогүй, дээр нь гаслангүй
Хэн байна тэр хүнийг
Хэлж нэрлэнэ, бярман хэмээн.

26:413
Тэнэг будангүй шуналаа цэвэрлээд
Тэвчээр сэрэмжээр ариусан цэвэршээд
Тэргэл сар мэт тунгалаг харагдах
Тэр хүнийг бярман хэмээнэ.

26:414
Төгсөхгүй шунах зовлонгоо гээсэн
Төөрүүлэгч мунхагийн харанхуйг гэтэлсэн
Төрөх үхэхийн голыг гаталсан
Төгөлдөр тэр хүн бярман мөн өө.

MO016內 2011/3/23 01:00 AM 頁面106

26:415
Орчлонгийн хүслийг огоот хаясан
Орон гэртээ хоргодохоо больсон
Очих нирваан тодорхой болсон
Онцгой тэр хүн бярман мөн өө.



26:416
Энэ хорвоогийн шуналаас салсан
Эрхэм сахилаа ягштал дагасан
Эргэж төрөхгүй нь тодорхой болсон
Энэ хүн бярман мөн өө.



26:417
Энэ хорвоогийн шунал тачаалыг
Эрхт тэнгэрүүдийн шунал тачаалыг ч
Эгнэгт хорин өөрийгөө чөлөөлөгч
Энэ хүн бярман мөн өө.



26:418
Хөөрөх, гутахын алийг ч орхисон
Хөөцөлдөх шунал хүслээ ч орхисон
Хөнөөгч сэтгэлийн гэмүүдээ дарсан
Хөлөг мэргэн бярман мөн өө.



26:419
Хаа сайгүй төрөх үхэх
Хамаг орчлонгийн зовлонгийн хүрдийг
Харан таниад шуналаа татагч л
Хамгаас тодорхой бярман мөн өө.

MO016內 2011/3/23 03:11 AM 頁面107



MO016內 2011/3/23 01:00 AM 頁面108

MO016內 2011/3/23 01:00 AM 頁面109

"Wherever the Buddha's teachings have flourished,

either in cities or countrysides,

people would gain inconceivable benefits.

The land and pepole would be enveloped in peace.

The sun and moon will shine clear and bright.

Wind and rain would appear accordingly,

and there will be no disasters.

Nations would be prosperous

and there would be no use for soldiers or weapons.

People would abide by morality and accord with laws.

They would be courteous and humble,

and everyone would be content without injustices.

There would be no thefts or violence.

The strong would not dominate the weak

and everyone would get their fair share."

~THE BUDDHA SPEAKS OF
THE INFINITE LIFE SUTRA OF
ADORNMENT, PURITY, EQUALITY
AND ENLIGHTENMENT OF
THE MAHAYANA SCHOOL~

DEDICATION OF MERIT

May the merit and virtue
accrued from this work
adorn Amitabha Buddha's Pure Land,
repay the four great kindnesses above,
and relieve the suffering of
those on the three paths below.

May those who see or hear of these efforts
generate Bodhi-mind,
spend their lives devoted to the Buddha Dharma,
and finally be reborn together in
the Land of Ultimate Bliss.
Homage to Amita Buddha!

NAMO AMITABHA
南 無 阿 彌 陀 佛

【蒙古文:法句經,"ILLUSTRATED DHAMMAPADA"in Mongolian language】

財團法人佛陀教育基金會 印贈
台北市杭州南路一段五十五號十一樓
Printed and donated for free distribution by
The Corporate Body of the Buddha Educational Foundation
11F., 55 Hang Chow South Road Sec 1, Taipei, Taiwan, R.O.C.
Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415
Email: overseas@budaedu.org
Website:http://www.budaedu.org
This book is strictly for free distribution, it is not for sale.
ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО
Printed in Taiwan
12,000 copies; March 2011
MO016-9294